

A vertical strip of the Mongolian flag is visible on the left side of the image, showing its characteristic red, blue, and yellow colors with the white "Torgoo" symbol in the center.


“Би өнгөрсөн дөрвөн  
жилийн хугацаанд  
өөрийгөө төгс, мундаг  
ажилласан гэхгүй.  
Зарчмаа сайн барьж,  
сэтгэлээрээ зүтгэсэн.

УИХ-ЫН ГИШҮҮН  
**ДАМБЫН** **БАТЛУТ**

Бүрэн эрхийн хугацааны ажлын тайлан | 2020-2024

## Гарчиг

- 4 Танилцуулга
- 5 Мэндчилгээ
- 6 Умардын гайхамшиг
- 16** УИХ-ын гишүүн  
Д.БАТЛУТ: Ам, ажил  
нь нэгдэж чаддаг хүн л  
жинхэнэ улстөрч
- 26** Эн түрүүнд  
үзэл санаа
- 28** УИХ-ын гишүүн  
Д.Батлутын Онцлох  
эшлэл
- 32** Солийн Данзангийн  
тэрсүү уг ба хойд  
бүсийн хөгжлийн нууц
- 38** Санаачилсан хууль,  
хуулийн төслүүд  
2020-2024
- 41** Хөрөнгө оруулалт  
2020-2024
- 42** 2021-2024 онд  
батлагдсан онцлох  
9 хууль





**53**

Хөрөнгө оруулалт  
бүтээн байгуулалт

**46**

Өнгөрсөн дөрвөн жилд  
иргэдэд хэрэгтэй  
ямар шийдвэрүүдэд  
нөлөөлөв?

**52**

Шинжлэх ухаан  
технологийн парк

**56**

Орхон, Хөвсгөл,  
Булганыхныг хангалиун  
амьдруулах төгс жор  
буюу Аж үйлдвэр,  
технологийн парк

**60**

“Хөгжлийн алтан  
гурвал” буюу Шар  
хөтөлийн зам

**64**

Бүгдээрээ хөгжье буюу  
хүний хөгжлийн тухай  
бодол

**66**

Дэлхийгээр дүүрэн  
мөнгийг дэнждээ татах  
боломж

**70**

Эргэх холбоо

**74**

Өрхийн үйлдвэрлэл ба  
итгэлцлийн хүч

**78**



**49**



**60**



**64**



## Товчхон

Д.Батлут нь нутгийн удирдлага төдийгүй ууган улс төрийн хүчин болох Монгол Ардын Намын бүхий л шатанд ажиллаж ирсэн нэгэн. Өдгөө Монгол Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүнээр ажиллаж байна.

УИХ-ын Д.Батлут эрүүл мэндийн салбарт онцгой анхаарч эмнэлгийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах асуудлыг онцолж бодит үр дүнд хүргэсэн ба хуурамч эм, өмийн хэрэгслийн асуудлыг Их хурлын чуулганаар анх хөндсөн гишүүдийн нэг билээ. Түүний өндөр оролцоотой ажилласан хянан шалгах түр хороо мянга мянган бүртгэлгүй, хуурамч өмийг илрүүлж байв.

Мөн Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч байхаасаа онцгой анхаарч ирсэн шинжлэх ухаан, технологи, инноваци, үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын нэг чухал зангилаа болох Шинжлэх ухаан, технологийн парк нь амжилттай ажиллаж байна. Тэрээр уг ажлын үргэлжлэл гэж хэлж болохуйц шийдлийн нэг болох Үйлдвэрлэл, технологийн паркийн үндэс суурийг баттай тавих, хөгжүүлэх ажлыг шат дараалалтай арга хэмжээ авсаар байна. Тухайлбал нэр бүхий гишүүдийн хамт "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл"-ийг өргөн барьж, 2022 онд УИХ-аар батлуулсан юм.

## Ерөнхий мэдээлэл

**Овог, нэр:** Дамбын БАТЛУТ

**Төрсөн огноо:** 1974.08.19

**Төрсөн газар:** Архангай аймгийн  
Хашаат сум

**Боловсрол:** Орхон аймгийн Ерөнхий боловсролын V дунд сургууль (1992); ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль, Инженер (2004); Удирдлагын академи, Төрийн удирдлага (2007);

**Улс төрийн хүчин:** Монгол Ардын Нам

**Ажилласан байдал:** "Эрдэнэт хивс" ХХК, Туслах ажилтан (1994-2000); "Дэлхийн Зөн Монголд" олон улсын байгууллага, Гүйцэтгэх захирал (2003-2006); Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжилтэн (2006-2007); Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч (2008-2012); Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч (2016-2020); Монгол Улсын Их Хурлын гишүүн (2020 оноос)

**Улс төрийн сонгуульт ажил:** МАН-ын гишүүн (1995), НАМЭХ-ны дарга (2006-2013); Баян-Өндөр сумын НАШБ-ын дарга (2010-2012); Орхон аймгийн МАН-ын дарга (2013-2024); Орхон аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч, Бүлгийн дарга (2008-2020)

**Гэр бүл:** Эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг

**Шагнал:** Их Монгол Улс байгуулагсаны 800 жилийн ойн медаль (2006); Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль (2011); Алтан гадас одон (2017)

**Холбоо барих:** batlutd@parliament.mn

# МЭНДЧИЛГЭЭ

Уншигч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Таны гартаа барьж буй энэхүү сэтгүүл нь УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ҮҮРГИЙН ДАГУУ ТА БҮХЭНДЭЭ ӨРГӨН БАРЬЖ БУЙ БҮРЭН ЭРХЭТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТАЙЛАН БИЛЭЭ. ЭНЭ ХУГАЦААНД БАГАГҮЙ АЖЛЫГ АМЖУУЛЖ, ОЛОН АЖЛЫН ЭХЛЭЛ ҮНДСИЙГ ТАВЬЖЭЭ.

Миний бие орон нутгийн удирдлага, иргэдтэйгээ нягт хамтран ажилласан нь бодит үр дүнд хүргэсэн юм. Бид улсын төсвийн багагүй хөрөнгөөр Орхон аймгийн шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, хөгжлийн алсын хараатай төслүүд болон соёл, боловсрол, шинжлэх ухаан, нийгмийн олон асуудлыг шийдвэрлэсэн бүтээн байгуулалтыг хийж чадсан билээ. Түүнчлэн бусад орны Засгийн газар, дипломат төлөөлөл болон санхүү, хөрөнгө оруулалтын байгууллагуудаас хөрөнгө татаж томоохон хэмжээний дэд бүтэц, инженерийн байгууламжийг бүтээн байгуулах их ажлыг эхлүүлээд байна.

2020-2024 оны хугацаанд багагүй хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татан төвлөрүүллээ. Тус хөрөнгийг бүсийн эрчим хүчний тогтвортой байдал, орон нутгийн дэд бүтцийн хөгжил, мянга мянган хүүхдийн бүх шатны боловсролын хүртээмж, Хойд бүсийн олон мянган иргэний эрүүл мэндийг сахин хамгаалах үйлс, нийгмийн баталгаа, ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд зарцуулсан юм.

Товчхондоо миний бие өнгөрсөн дөрвөн жилийг "Аядуу боловч гүн итгэлтэйгээр та бүгдээдээ амласан ажлаа урагшлуулж багагүй үр дүнд хүрсэн цаг хугацаа" хэмээн дүгнэж байна.

Энэ удаагийн тайлан маань их онцлогтойгоор хийгдлээ. Манай ажлын алба Монголын болон олон улсын улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаар олон жил мэргэшин бичсэн нэр хүндтэй тоймч, нийтлэлчдэд хүсэлт илгээж нэг ёсны хөндлөнгийн дүн шинжилгээ хийлгэснээ бүрэн эхээр нь нийтлэж байна. Мөн өөрийн үзэл, хөгжлийн тухай бодол санаагаа тусган бичсэн нийтлэл болон илэн далангүй дэлгэрэнгүй ярилцлагaa хүргэж байна.

Та бүхэн мэргэн оюундаа тунгаанаа буй заа.



УИХ-ЫН ГИШҮҮН ДАМБЫН БАТЛУТ





Умардын гайхамшиг  
**ХӨВСГӨЛ**











Умардын гайхамшиг

# БУЛГАН











Умардын гайхамшиг

# ОРХОН





УИХ-ЫН ГИШҮҮН Д.БАТЛУТ:

# Ам, ажил нь нэгдэж чаддаг хүн л жинхэнэ улстөрч

УИХ-ЫН ГИШҮҮН Д.Батлуттай ярилцлаа.

**Ярилцлагаа нэг сониуч асуултаар эхэльье. Та нэлээд жин хаячихаж. Эрүүл мэндийн шалтгаан байна уу, эсвэл...?**

Эрүүл мэндийн хувьд ямар ч асуудал байхгүй. Би жингийн илүүдэлтэй байхдаа жилд хоёр удаа ёс мэт эмнэлэгт хэвтдэг байлаа. Хоёр жилийн өмнөөс Эрдэнэтийнхээ өмнэлгийн хоол зүйчээс эрүүл хооллолтын зөвлөгөө авсан. Тэгээд л хооллолтдоо анхаарч, өдөрт 20 км газар дугуй жийж эхэлсэн. Хоёр жилийн хугацаанд 45 кг хаясан. Бие хөнгөрөөд сайхан болчихоор бусдадаа нөлөөлөхсөн гэж боддог юм байна. Хэд хэдэн хүнд нөлөөлж чадсан шүү (инээв).

**"Дэлхийн зөн"-д нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн асуудал хариуцсанаар ажлын гаралаагаа эхэлсэн гэж сонссон. Тэнд ажилласан он жилүүд танд юу өгөв, ямар сургамж үлдээв?**

Миний анхны ажил ч биш л дээ. Хөдөлмөрийн гарaa маань "Эрдэнэт хивс"-ийн ноос боловсруулах үйлдвэрийн туслах ажилтнаас эхэлж байлаа. Тэндээ долоон жил ажиллаад "Дэлхийн зөн"-д ажилласан. Инженер мэргэжлээрээ ажиллаагүй минь анхнаасаа нийгэмд ойрхон ажилласантай холбоотой гэж боддог юм. "Дэлхийн зөн"-д нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн ажил хийж явахдаа үзсэн, харсан, мэдэрсэн зүйл минь олон нийтийн ажилд уруу татсан. Тэнд байхдаа зорилтот бүлгийнхэнтэй маш ойрхон ажиллаж байсан л даа. Өвлийн хүйтэн, зуны халуун, ер аль ч үед өнөөдүүлийнхээ

хойноос "гүйнэ". Эргэж тойрно. Нэг хэсгийг нь зэмлэнэ, нөгөө заримыг нь аргадна. Заримтай нь хоолны мөнгөө хуваана. Заримд нь түлээ түлш дөхүүлж өгнө. Өнгөц харсан хүнд бол хүсмээр ажил биш. Миний хувьд мэдээж бүх зүйл хялбар байгаагүй. Гэхдээ тэдний өөрчлөлт надад урам өгдөг байсан.

**"Дэлхийн зөн"-д ажиллах хугацаанд цөөнгүй айл өрх хүнд нөхцөлөөсөө гарсан шүү. Манай байгууллагаас хэрэгжүүлдэг өрхийн**

үйлдвэрлэлийг дэмжсэн хүүгүй бичил зээлийн хөтөлбөрт хамрагдсан хүмүүс амжилтын түүхийг жинхэнэ утгаар нь бүтээдэг байлаа. Тэр жилүүд хүний тухай, нийгмийн тухай, хөгжлийн тухай бодлыг минь өөрчилсөн. Бүхний түрүүнд тавих зүйл бол хүн болоод хүний хөгжил л юм байна гэдгийг ой тойндоо ортол ойлгосон. Бас ганцаараа биш багаараа зүтгэж байж их ажлын ард гардаг гэсэн итгэл үнэмшигийг олж авсан. Өдий хүртэл хийсэн бүх ажлын минь ард баг, хамт олны минь хүч бий. Нийгмийн идэвхтэй хүн чинь олон улсын байгууллагад ажиллахын зэрэгцээ Оюутны холбоо, Залуучуудын холбооны сонгуульт ажилд зүтгэдэг байлаа. Тэр жилүүдэд хамт ажиллаж явсан багийнхантайгаа өнөө ч ойр дотно шүү.

**Улс төрд яг хэзээ орсон юм бэ?**

Өө, их залуудаа (инээв). Улс төрд хөтөлсөн хүн гэвэл манай аймгийн МАН-ын хорооны

дарга. Харин улс төр, төр захирагааны ажлын түүх гэвэл хориод жилийн өмнө Орхон аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт мэргэжилтнээр орсноор эхэлсэн. Дараа нь Монгол Улсын хамгийн их хүн амтай Эрдэнэт хот буюу Баян-Өндөр сумын засаг

даргын орлогч хийж байлаа. Зуун мянга гаруй хүн амтай сумын Засаг даргын орлогчоор ажилласан минь төрийн ажил ямар байх ёстойг илүүтэй мэдрүүлсэн он

жилүүд. Тэр үедээ Орхон аймгийн НАМЗХ-ны дарга, дараа нь аймгийнхаа намын дарга болж байсан юм. Одоо хүртэл аймгийнхаа намын даргаар ажиллаж байна. 2008 оноос Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчаар томилогдож зүтгэсэн. Их зүйл амжуулахыг хичээж, бодож төлөвлөсөн ч амжуулаагүй ажлууд бас бий.

**Эрдэнэтийнхний сонголт санаанд оромгүй шүү. МАН-ыг ч, АН-ыг ч, бүр бие даан нэр дэвшигчийг ч гаргаад ирнэ. Улаан, цэнхэр тойрог гэж тодотгох аргагүй сонирхолтой газар. Ийм газарт аймгийн намын дарга олон жил хийх хэцүү биз?**

Та зөв анзаарч. Эрдэнэт улс төрийн хувьд их хурц газар. Сонголтууд нь таны хэлсэн шиг санаанд оромгүй. Нам хоорондын өрсөлдөөн битгий хэл нэг нам доторх өрсөлдөөн асар их. Ийм газарт том намыг төлөөлж удирдах ажил хийнэ гэдэг амар биш. Гэхдээ л хэцүү бүхний ард гарч

амжилт бүтээж явна. Ер нь тэгээд зориод, сэтгэл гаргаад зүтгэхэд болохгүй бүтэхгүй зүйл гэж үгүй дээ.

### Ингэхэд та Орхон аймгийн ИТХ-д хэдэн удаа сонгогдох байлаа?

Аймгийнхаа ИТХ-д 2008-2020 он хүртэл ажилласан. Төрийн ажил амар биш ч гэлээ миний хувьд гартаа оруулаад авахад хэцүү байгаагүй. Орон нутгаас, бүр анхан шатнаас нь гарч ирсэн улстөрч гэвэл бараг би болов уу. Бүр анхан шатнаас нь ажиллаад зүтгээд удирдах төвшний ажил хийсэн хүнд нэг "гэм" байдаг юм байна. Асуудлаа углуургаар нь харчихаад, өнөө ажлаа яг амжуулна гээд зүтгэхидэг "гэм". УИХ-ын гишүүн болоод ч арилдаггүй "гэм" юм байна (инээв).

**Орхон аймгийн  
Засаг даргаар  
ажиллахдаа  
амжуулсан  
бүхнээ  
тоочвол олон  
зүйл ярих  
хэрэг гарах нь  
оилгомжтой.**

**Хийсэн ажлаа ганцхан ажил,  
нэг статистикаар илэрхийлээч  
гэвэл юуг онцлох вэ?**

Манай аймаг улсад найман удаа шилдэг аймаг болж байсан юм. Намайг Засаг дарга байх хугацаанд гурван жил дарааллан шилдэг аймаг болж байсан. Монгол Улсад "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр хэрэгжихээс хагас жилийн өмнө манай баг "Элэгний вирусгүй Эрдэнэт хот" хөтөлбөр эхлүүлж байлаа.

Тэр хөтөлбөр хэрэгжих үед 49 хүн анхдагч хавдрынхаа үед оношлогдсон. 49 айлыг хожим үүсэх дарамт, бэрхшээлээс салгасан гэсэн уг. Анх Засаг дарга болохдоо хүний хөгжлийг нэгт тавьж ажиллахаа зарлаж байлаа. Яг дараа жил нь Засгийн газар хүний хөгжлийн бодлого ярьж баталсан гэх мэтээр тоочвол олон ажил бий.

**Та чинь жинхэнэ мерит  
зарчмаар шат алгасалгүй явж  
ирсэн улстөрч байна шүү дээ.  
Ер нь таныхаар улс төр гэж  
юу вэ, улстөрч гэж хэн бэ? Улс  
төрийн үнэт зүйл гэж юу юм  
бол?**

Хэд хэдэн зүйл онцолмоор байна. Нэгдүгээрт улс төр ямар байлаа ч гэсэн заавал нийгэмдээ, хүндээ чиглэх ёстой. Хүнд хэцүү үед ард түмнийхээ тулах тулгуур, тайван энх цагт хөгжлийг урагшлуулах хүч болох учиртай. Улс төрийн амин зарчим

гэвэл ерөөсөө л энэ. Зүүний, барууны үзлээс үл хамааран энэ зарчмыг юуны түрүүнд баримтлах ёстой гэж хардаг. Хоёрдугаарт улс төр бол нийгмийн харилцаа. Нийгмийн ёс зүйтэй, тогтвортой харилцаа байж гэмээнэ улс төрийн үнэт зүйл бий болно. Ингээд харахаар улс төр гэдэг бол бие даасан шинжлэх ухаан, харилцааны асуудал. Ам, ажил нь нэгдэж чадсан цагт сая нэг "би улс төр хийлээ" гэж нүүр бардам хэлэх учиртай. Дан

ганц ам байхаар туйлширан, попорсон хэлбэр рүү орчихоод байна л даа. Улстөрч гэж хэн бэ гэж та сая асуулаа. Нийгэмд бодол санаагаа ойлгуулж, тэр хэрээрээ орон зайгаа бий болгож чадсан хүнийг л улстөрч гэх болов уу. Улс төр болон улстөрчийн үнэт зүйл гэвэл би нэг л зүйл хэлнэ. Ерөөсөө л зарчимтай байх ёстой. Сэтгэлтэй хүн л зарчимтай байдаг гэдэгт би хувьдаа эргэлздэггүй.

**Улс төрд цаашаа илүү хол  
зам туульяа гэвэл тойрог  
руугаа гүймтгий, тойргийнхoo  
асуудал дээр тод чанга  
дуугарч зүтгэхээс илүү зарим  
нэг халуун сэдэв дээр попрох  
ёстой юм биш үү?**

Улс төр бол попордог биш ажилладаг талбар. Би улс төрийг хүмүүст хэрэгтэй шийдэл гаргахад чадах хэрээрээ нөлөөлж, чимээгүй ажилладаг тийм л орон зай гэж хардаг. Тэр ч зарчмаараа ажиллах явваа. Цаашид энэ зарчмаасаа ухрахгүй. Гэхдээ УИХ-ын гишүүн хуулиараа олон нийтэд ажлаа тайлагнах үүрэгтэй. Тиймээс би энд тантай ярилцаад сууж байна. Магадгүй намайг улс даяар мэддэггүй байж болно. Гэхдээ "Батлут гэдэг улстөрч энэ чиглэлд үнэхээр юм хийжээ, яах аргагүй нөлөөлж чаджээ" гэж хэлүүлэх хэмжээний улстөрч болж төлөвшсөн байх аа. Би өнөөхөндөө өөрийгөө ингэж л дүгнэхээр байна. Миний хувьд Монгол хүнийг эрүүл, баян байгаасай гэж хүсч, тэр орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллахыг илүүд үздэг. Тэр ч утгаараа эрүүл мэндийг хамгаалах өөрчлөх чиглэлд түлхүү анхаарч ажилладаг.



Монгол Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөсний дараа  
тангарагийн хуудсанд гарын үсэг зурж буй нь, 2020 он

Би улс төрд шинэ хүн биш л дээ. Хорь гаруй жил улс төрд зүтгэхдээ Эрдэнэт гэдэг том хотод олон хариуцлагатай алба хашсан тухай өмнө дурдсан. Орхон аймгийн Засаг даргаар ажиллахдаа Эрдэнэт хотоо Монголын Цахиурын хөндий болгоно гэсэн амбиц тавиад ажиллаж байлаа. Эрдэнэт хот Монголын Цахиурын хөндий болчихвол хожих хүмүүс нь иргэд өөрсдөө. Эрдэнэтчүүдийн орлого өснө гэсэн үг. Нэг энгийн хэрнээ маш үнэн логик бий. Иргэд хөрөнгөжих хэрээр

улс хөгждөг. Ингээд хархаар таны түрүүний хэлдэг "тойрог руугаа гүймтгий" гэдэг тодотголын цаад утга гарч ирж байгаа биз. Улстөрчид бултаараа Улаанбаатараас олон зуун км алслагдсан жижигхэн буйдхан сумаас улсын хөгжил эхэнэ гэдгийг олоод харчихвал улсаараа хөгжих тийм ч том асуудал биш гэж хардаг.

**Жижиг хэрнээ том өнцөг байна шүү. Ингэхэд та орон нутгаас УИХ-д орж ирсэн улстөрчийн хувьд давуу**

### **болон сул талаа юу гэж тодорхойлох вэ?**

Орон нутгийнхаа бүх асуудлыг нэвт шувт мэддэг маань маш том давуу тал болсон гэж хардаг. Өөрөөр хэлбэл орон нутагт үүссэн асуудлуудыг шийдэх гарцаа олж харчихаад УИХ-д орж ирсэн. Сул тал гэвэл мөн л энэ асуудалтай холбогдоно. Ямар ч асуудлын гарцыг Засгийн газрын төвшинд харчихдаг "гэм"-тэй (инээв). УИХ хууль баталдаг, Засгийн газар тод шийдэл олж хэрэгжүүлдэг үүрэгтэй. Гэтэл



Эрдэнэт ШУТП-д бойжуулж буй Будгийн үйлдвэр

би гэдэг хүн УИХ-ын гишүүн байж асуудлын зохицуулалтыг тодорхой шийдэлтэй нь, амьдралд буулгах гарцтай нь ярж “том толгойлоод” байсан сул тал бий шүү (инээв).

**Аймгийн Засаг дарга нар асуудал дунд ороод шийдээд явдаг онцлогтой. Таны хувьд тэр зангаа л тавихгүй байж. УИХ-д суух хугацаандаа орон нутагтаа яг ямар ажлууд амжуулснаа сонирхуулаач?**

Хотдоо хамгийн хүнд гэж хэлж болохуйц асуудлуудыг шийдэх төслүүдийг хэрэгжүүлсэн. Үерийн нэгдсэн далан, хог боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлж чадлаа. Орон нутагт анх удаа Шинжлэх ухаан технологийн парк байгуулж орон нутгийн хөгжилд нэмэртэй төслүүдийг бойжуулсандaa олзуурхдаг. Инкубатор маягийн үүрэг гүйцэтгэдэг л дээ, манай аймгийн Шинжлэх ухаан технологийн парк. Бойжуулсан төслүүдээс маань амжилттай сайн хэрэгжиж яваа хоёр

том төсөл бий. Нэг нь евроСтандартын будгийн үйлдвэр, нөгөө нь гагнуурын электродын үйлдвэр. Ганцхан цагийн дотор хатдаг, эрүүл мэндэд хоргүй евроСтандартын будаг маань гэхэд л Эрдэнэтээс гадна Улаанбаатарт борлуулагдаж байна. Яг бүрэн хүчин чадлаараа ажиллавал Монгол Улсын будгийн нийт хэрэглээний талыг дангаар нь хангах хэмжээний том үйлдвэр. Бас банкны шалгуурт тэнцдэггүй иргэдэд хүүгүй, барьцаагүй зээл олгосондоо сэтгэл дүүрэн байдаг.

**Хүүгүй, барьцаагүй зээл гэхээр санаанд багтажгүй юм. Хууль зүйн талаасаа ч ийм зээл гаргах боломжгүй биш үү. Банкны шалгуурт тэнцдэггүй иргэд гэхээр жижиг, дунд үйлдвэрлэгчдээс өөр ойлголт болж таарч байна уу?**

Улстөрчид жижиг, дунд үйлдвэрийг дэмжих ёстой гэж их ярьдаг. Гэхдээ жижиг, дунд үйлдвэрийн ихэнхийг бичил бизнес эрхлэгчид эзэлдгийг огт анзаардаггүй. Жижиг дунд үйлдвэрлэлийг 200, 300 сая төгрөгөөр эргэлддэг гэж хараад зээлийн шалгуур тавьчихаар тэдний ихэнх болох бичил бизнес эрхлэгчид тойргийн гадна үлдчихдэг. Бичил бизнесийнхний эргэлт тун бага шүү дээ. Жилийн эргэлт нь 20, 30, 40 саяар л яригддаг. Орон нутагт анхан шатнаас нь ажилласан учраас миний хувьд энэ онцлогийг олж хараад бичил бизнес эрхлэгчдэд хүүгүй, барьцаагүй зээл олгох ажлыг эхлүүлсэн.

Таны асууж буй өнцөг зөвлөдөө. Хүүгүй, барьцаагүй зээл өгөх хууль зүйн үндэс гээд яривал тийм зүйл байхгүй. Гэхдээ хийе гээд зориход гарц шийдэл олддог. Бид Шинжлэх ухаан, технологийн паркаа түшиглээд хүүгүй, барьцаагүй зээл олгосон.

**“Миний хувьд орон нутагтаа үүссэн асуудлуудыг шийдэх гарцтай нь олж харчихаад УИХ-д орж ирсэн.**

**Ухаалаг шийдэл байна. Хүү, барьцаагүй зээлийн эргэн төлөлт ямар байгаа вэ, жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн эргэн төлөлт лав хэцүүхэн яваа харагддаг...?**

Гайхмаар нь ямар ч барьцаа, хүүгүй олгосон зээлийн эргэн төлөлт маш сайн байгаа. УИХ-ын гишүүнээр ажиллах хугацаандаа ч бичил бизнес эрхлэгчдэд өндөр босго тавибал зээлд хамрагдах боломжгүйг ойлгуулах

Чиглэлд хэр чадлаараа зүтгэлээ. Үр дүн нь ч гарч эхэлсэн.

**УИХ-Д ДӨРВӨН ЖИЛ СУУСНЫ ЭЦЭСТ ЭРГЭЭД ХАРАХАД ОРОН НУТГАА БҮРЭН ТӨЛӨӨЛЖ, АСУУДЛУУДЫГ НЬ НҮҮР БАРДАМ ШИЙДЭЖ ӨГЧ АЖИЛЛАЖ ЧАДАЖ УУ?**

Би өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд өөрийгөө төгс, мундаг ажилласан гэхгүй. Зарчмаа л сайн барьж ажилласан. Амлалтынхаа 90

орчим хувийг биелүүлсэн. Төрийн ажил сэтгэл дээр л тогтдог. Сэтгэл гаргаж чадвал ямар ч ажил бүтэлтэй, үр дүнтэй байдаг. Олон жилийн өмнө би хэвлэлд ярилцлага өгөхдөө “сайн улстөрч бол хүн байх ёстой” гэж хэлж байсан. Одоо ч тэр бодол минь хэвээрээ. Хэнтэй ч сайхан харилцдаг, асуудлыг нь сонсдог, сэдэл, санаа өгдөг, жижиг ч гэлээ хэмжээнд нөлөөлөгч, соён гэгээрүүлэгч байх учиртай.

**“Улстөрч болъё гэвэл эхлээд хүн байх ёстой” гэсэн үгийг чинь “Ямар уянгын халилтай ярьдаг нөхөр вэ” гэж хүлээж авах хүмүүс цөөнгүй гарах байх шүү, ер нь улстөрчдийн ийм агуулгатай яриа хөөрөөг нийтээрээ их хардангуй хүлээж авдаг болчихож?**

Уянгын халилтай сонсогдож магадгүй. Гэхдээ хүн хүнээ хүндэтгэж, хайлрахаас бүх зүйл эхэлдэг. Амьдрал ямар үүрдийнх биш.

**“Чадаагүй юмаа бөөрөнхийлөөд олон юм ярих хэрэггүй.**



Хорвоод амьдрах богинохон хугацаандаа "хүн"-ээрээ байхыг хүсдэг.

**Улстөрчдийг ингээд ярихаар иргэддээ худлаа хайр зарлалаа гэж шүүмжилцгээдэг, ялангуяа сонгуулийн өмнөх ийм цагт...?**

Иргэдийнхээ дунд амьдарч, борог амьдралыг түүлж гарч ирсэн улстөрчдийн хувьд энэ худлаа үг биш л дээ. Асуудлын гүнийг мэдрээд ирэхээр угаасаа л хүнтэй хүнлэг харилцахаас бүх зүйл эхэлдэгийг ойлгож мэдэрдэг нь амьдралын жам, хууль шүү дээ. Тэгээд ч би сайндаа УИХ-ын гишүүн болоогүй. Олон түмэн итгэсэн учраас тэднийг төлөөлж төрд суугаа хүн. Тэгж гарч ирсэн хүн бусдын жаргал, зовлонг ойлгодог, өөрийн төлөө биш бусдын төлөө шийдвэр гаргадаг байх нь наашлуулаад яривал зарчмын, цаашлуулаад харвал сэтгэлийн асуудал.

**Бусдын төлөө гээд зориод зүтгэсэн чинь хувь улстөрчийн чинь карьеерт хүндхэн тусахаар бол бас хэцүү. Ийм шалтгаанаар маш олон улстөрч хувнаа бодож довоо шарлуулах замыг сонгодог. Танд тийм тохиолдол байсан уу?**

Байгаагүй гэж нүүр бардам хэлнэ. Түмнийг төлөөлж улс төрд орсон хүн зарим үед түмний төлөө өөрийгөө золиосолж чаддаг байх ёстой. Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүн энэ ажлыг хийснээр, ийм шийдвэр гаргаснаар үр дүн нь бусдад яаж нөлөөлөх бол гэж хамгийн түрүүнд бодож үздэг байх

хэрэгтэй. Аль болох олон хүний амьдралыг эергээр өөрчлөх гэж л шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа биз дээ. Түрүүн хэлсэн ч давтаад хэлье. Ам, ажлын зөрүү гаргахгүй амьдарч чадвал сайн улстөрч гэсэн үг.

**Таны хувьд ам, ажлын зөрүү гаргасан удаа бий юу?**

Тийм зүйл гаргахгүйг хичээдэг. Гэхдээ амьдрал баян, асуудал хэзээд тулгарч байдаг.

**“ Улстөрчид жижиг, дунд үйлдвэрийг дэмжих ёстой гэж их ярьдаг. Гэхдээ жижиг, дунд үйлдвэрийн ихэнхийг бичил бизнес эрхлэгчид эзэлдгийг огт анзаардаггүй.**



Биелүүлээгүй амлалт бий. Би өнгөрсөн сонгуулиар нэр дэвшихдээ шахмал түлшний үйлдвэр байгуулна гэж амлаж байсан. Харамсалтай нь чадаагүй. Чадаагүй юмаа бөөрөнхийлөөд олон юм ярих хэрэггүй. ГОК, оросуудтай хамтраад шахмал түлшний үйлдвэр байгуульяа гээд технологийг нь оруулж ирсэн.

Гаргасан бүтээгдэхүүнээ шинжлүүлэхэд шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсан. Тийм дүгнэлт гарсан учраас зогсоохоос өөр арга байгаагүй. Гэхдээ сайн мэдээ бий. Манай Шинжлэх ухаан, технологийн паркад бойжсон төслийн залуус эко түлш үйлдвэрлэж эхэлж байна. Миний хувьд чадлынхаа хэрээр дэмжиж байгаа.

**Цагаан тоосны асуудлыг шийдсэн гэсэн постны чинь доор эсэргүүцсэн коммент олон харагдсан. “Эрдэнэт байсан цагт цагаан тоос арилахгүй”, “Ингэж худлаа шоудахаа болимоор юм” гэж ирээд шүүмжилсэн байсан?**

Мэдээж Эрдэнэт ажиллаж байгаа цагт цагаан тоосноос салахгүй. Тэр үнэн. Гэхдээ дөрвөн жилийн өмнө УИХ-д нэр дэвших үед цагаан тоосон дээр ямар ч шийдэл байхгүй гэж байсныг бодоход хүмүүст хэрэгтэй маш том шийдвэрийг Засгийн газар гаргачихсан. Суурьшлын бүсээс хол зайд хаягдлын асуудлыг шийдэхээр болсон. Ийм том шийдвэрт нөлөөлж чадсандaa баяртай байгаа. Иргэдийн эрүүл мэндэд санаа тавьсан маш том шийдэл. Үйлдвэр анхны бүтээгдэхүүнээ гаргасан 46 жилийн тэртээд хаягдлын аж ахуйгаа мэдээж нам дор газар ухаж байгуулсан. Хаягдал нэмэгдэх тусах овоолго дээшлэх нь тодорхой шүү дээ. Дээрээс нь юм асгах шийдэл бий ч хэтэрхий өндөр болчихсон учраас тоос бужигнаад байгаа юм. Эрдэнэт үйлдвэр ахиад 60 жил ажиллана. Ирэх жилүүдэд өмнөх 46 жилийнхээ замаар алхаж болохгүй. Өөрөөр хэлбэл

үйлдвэрийн овоолгыг зоригтой шийдвэр гаргаж суурьшлын бүсээс холдуулахаас өөр аргагүй. Бид Эрдэнэт үйлдвэрт "Үйлдвэр байсан цагт цагаан тоос арилахгүй. Цагаан тоосоо суурьшлын бүсээс холдуулахын тулд байгаа бүх боломжоо ашиглая. Аймгийнхаа багахан газар нутгаас 8000 га газрыг шийдэж өгье. Та нар хайгуулын лицензтэй газар дотроо худэргүй бүсээ ол. Аймгаас шийдвэр гаргая" гэсэн тодорхой санал тавьсан. Энэ бүхний эцэст Орхон аймгийн иргэдийн хурал 4.4 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар шийдсэн. 4.4 мянган га-г Булган аймаг шийдэхээр болсон. Өөрөөр хэлбэл Эрдэнэтийн хаягдлын асуудлыг суурьшлын бүсээс хол, өмнөхөөсөө өөр технологиор шийднэ. Австралийн технологиор далан үүсгэж өтгөрүүлж хаях юм. Өмнө нь бол шууд хаядаг байсан.

#### **Өтгөрүүлснээр бараг тоосжилтгүй болчих нь ээ?**

Тэгнэ. ТЭЗҮ нь эхэлчихсэн. Таван жилийн дараа ашиглалтад орчихно.

#### **Ингэхэд Эрдэнэтийг яагаад "Цахиурын хөндий" болгоё гэж зорьсон юм бэ?**

Эрдэнэт бол мэдлэг, технологийн хамгийн их нөөцтэй хот. Улсдаа төдийгүй дэлхийд гэж яригдаг уулын баяжуулах үйлдвэртэй хотын хувьд зорих ёстой амбиц л даа. Тэр утгаар нь Эрдэнэт хотоо Монголын Цахиурын хөндий болгоё гэж зорьсон юм. Засаг даргаар ажиллаж байхдаа

Шинжлэх ухаан, технологийн паркийг анх удаа Эрдэнэтэд байгуулсан минь цаанаа ийм учиртай. Улсын хэмжээнд жишиг болохуйц энэ асуудалд Монгол Улсын Засгийн газраас онцгой анхаарч, бодлогоор дэмжиж яваад олзуурхдаг. Шинжлэх ухаан технологийн ололт, монгол технологийг шууд үйлдвэрлэл болгож

**"*Би өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд өөрийгөө төгс, мундаг ажилласан гэхгүй. Зарчмаа л сайн барьж, сэктгэлээрээ зүтгэсэн.***

хувиргах хэрэгтэй. Улс, бүсийн хөгжлийн төвүүд импортлогч биш экспортлогч болох хэтийн зорилго руугаа хандан ажиллах цаг холгүй гэж хардаг. Одоо Эрдэнэтэд "Үйлдвэрлэл технологийн парк"-ийн эрчим хүч, усан хангамж, төмөр замын дэд бүтцийг байгуулах бүтээн байгуулалтын ажил төслийн 1200 га талбайд ид өрнөж байна.

**Таны байнга ярьдаг "өрх бүрийг үйлдвэрлэгч болгох" уг нь гоё санаа. Гэхдээ уриа төдий явсаар хэчинээн ч жил болчихов доо. Өрх бүр үйлдвэрлэгч байх бодит суурь нь байна уу?**

Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн Аж үйлдвэр, технологийн парк байгуулагдсанаар өрх бүр үйлдвэрлэгч байх жинхэнэ суурь тавигдана. Хүн бүр

үйлдвэрлэгч байвал улсаараа хангалаан хөрөнгөлөг амьдрах боломжтойг олж хардаг нь тун цөөн. Ний нуугүй хэлэхэд, сүүлийн 30 жил буруу явсан хөдөө аж ахуйн бодлого одоо ч буруу хэвээр байна. Монголчууд хөдөө аж ахуйн түүхий эдээ гүн боловсруулдаггүй, бүгдийг нь урагшаа гаргадаг учраас өргөн хэрэглээний бүхнээ үнэтэй хэрэглэхээс аргагүй. "Үйлдвэрлэл технологийн парк"-аа дагуулаад Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк байгуулчихвал түүхий эдийн татан авалт, анхан шатны гүн боловсруулалт сайжраад ирнэ.

#### **Үйлдвэр технологийн парк дагасан Хөдөө аж ахуй үйлдвэр технологийн парк байгуулснаар гарах үр өгөөжийн тооцоо гарсан уу?**

Нарийн тооцооллууд бий. Наад зах нь хөдөө аж ахуйн экспортоос олдог нэг тэрбум доллар маань найм, есөн тэрбум болж өснө. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв загвараар эдийн засгийн эргэлтэд оруулбал дэлхийд органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болно. Дотоодын хэрэгцээгээ хямд нийлүүлж, зөрүүг нь экспортоосоо олж болно. 80 сая малаа эдийн засгийн эргэлтэд зөв оруулчихвал иргэд баян амьдрах бүрэн боломжтой.

**Өрхийн үйлдвэрлэл эрхэлж иргэн бүр баян байх боломжид тулгардаг гол бэрхшээл гэвэл та юуг онцлох вэ, мэдээж шийдлийг нь бас сонирхож байна?**

Манайханд тулгардаг гол бэрхшээл гэвэл гарал үүсэл тодорхойгүй гэгдээд экспортлох боломжгүй болчихдог. Үүнд онцгой анхаарах хэрэгтэй. Дэлхийн жишгээс харахад улс орнууд жижиг дунд буюу өрхийн үйлдвэрлэлээ ихэд чухалчлан дэмждэг. Солонгост гэхэд дэлхийд алдартай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг корпораци нь бүтээгдэхүүнийхээ сав баглаа боодлыг өрхийн үйлдвэрлэлд хариуцуулдаг байх жишээний. Өргөтгөсөн хувилбараараа дэд бүтцийн асуудлыг хойд бүсэд оруулж ирэхэд онцгой анхаарч байгаа нь цаанаа ийм учиртай. Ингэж байж хойд бүсийн өрхийн үйлдвэрлэл томорно.

**Монгол Улс сүүлийн 30 жилийн хугацаанд бүсчилсэн хөгжлийг төр засгийн**

**түвшиндөө ярьж, бодлого хөтөлбөр баталсаар ирсэн ч нийслэл рүү чиглэсэн урсгал тасрахгүй байна. Гол шалтгаан нь юу юм бол?**

Хүн амын төвлөрөл нийслэл болоод том суурингүүд руу чиглэж буйг хүчээр хязгаарлах боломжгүй. Орон нутгийг хөгжүүлсэн төрийн оновчтой зөв бодлогыг тууштай, үе шаттай хэрэгжүүлж байж энэ урсгал зүй жамаараа саарна. Иймд орон нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хэрэгтэй. Тэгээд зогсохгүй мах сүү, арьс ширийг нь боловсруулах үйлдвэр байгуулах шаардлага бий. Энэ үйлдвэрүүд том байх албагүй. Жижиг дунд гэж төлөвлөх нь ч зөв шийдэл биш. Том болоод жижиг, дунд үйлдвэрлэл жамаараа хөгжөөд явах нь тодорхой.

Орон нутгийн бүх иргэнд өгөөж хүртээе гэвэл мал аж ахуй дагасан өрхийн үйлдвэрлэл рүү шилжих ёстой.

**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга хоёр жилийн өмнөөс хэрэгжиж өхэлсэн. Орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлд хуульд орсон хамгийн сайн зохицуулалтыг онцлооч?**

Удирдлагын босоо тогтолцоо хэт давамгайлсан, эрх мэдлийн төвлөрөл ихэссэнээс орон нутгийн бие даасан байдал алдагдсан байсан юм. Хуулийн шинэчилсэн найруулгад орон нутагт анх удаа төсвийн болон эдийн засгийн зохих эрх мэдлийг олгосон нь маш чухал зохицуулалт болсон.



**Яг хэрэгждэг бол олон сайн  
өөрчлөлт байна шүү...?**

Яг үнэн. Эдгээр зохицуулалт амьдрал дээр зөв, зүйтэйгээр амь орж биеллээ олж хэрэгжих л маш чухал.

**Засаг захиргаа, нутаг  
дэвсгэрийн нэгж, түүний  
удирдлагын тухай хуулийн  
шинэчлэлээр нутгийн өөрийн  
удирдлагад иргэний оролцох  
оролцоо, эрхийг тодотгож  
өгсөн. Иргэдэд хуулиар  
олгогдсон эрхийн талаар  
ярилцлагаа үргэлжлүүлэх үү,  
хөёулаа?**

Нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангана гэдэг маш чухал. Тухайлбал "Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй" гэсэн заалт туссан. Тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн амьдралд үгүйлэгдэж байгаа асуудлыг иргэд өөрсдөө санаачлах, хэлэлцэж шийдвэр гаргуулахаар хандах эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн гэсэн үг.

**Ирэх сонгууль бүсчилсэн  
тойргоор явна. Бүсчилсэн  
хөгжлөө тодорхойлохын тулд  
сонгуулийн тойргийг бүсчилж  
байна гэж хараад байгаа. Таны  
хувьд хойд бүсийн хөгжлийг  
хэрхэн харж байгаа вэ?**

Монгол Улсын хөгжлийн гол цөм нь эдийн засгийн хөгжил гэдэгтэй маргах хүн гарахгүй байх. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар ХОЙД БҮС гэдэгт Орхон, Хөвсгөл, Булган аймаг багтаж байгаа. Уг бүсэд Монгол Улсын хүн ам, дотоодын нийт бүтээгдэхүүн, нийт газар нутгийн 10, газар тариалангийн 12, мал аж ахуйн 15 хувь төвлөрдөг. Эрдэнэт хот аж үйлдвэрийн салбараар, Хөвсгөл аймаг аялал жуулчлалын салбарын хөгжлөөрөө улсдаа тэргүүлдэг бол Булган аймаг газар тариалангийн салбарын үзүүлэлтүүдээрээ гуравт жагсдаг. Сул тал нь гурван аймгийн дунджаар нэг хүнд оногдох ДНБ-ны хэмжээг тооцвол улсын дунджаас 15 хувь доогуур байна. Хүн ам, эдийн засгийн өсөлт удаашралтайд тооцогддог. Иймд асуудлаа шийдэхийн тулд аймаг тус бүрийн онцлогт тохирсон шийдлүүд гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай.

**Хойд бүсийг хөгжүүлэх тухайд  
танд ямар гарц байна?**

Эрдэнэт хот бол инженерүүдийн хот. Өнгөрсөн жилүүдэд бид нөөцдөө тулгуурлаж Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн паркыг байгуулсан. Үр дүнгээ ч өгсөн. Яг энэ загвар туршлагаараа Булган, Хөвсгөл хэрэгжүүлэх боломжтой. Яг тухайн аймагт нь тохирсон технологи, инновациын шийдлүүдийг гаргаж нутагшуулбал жижиг, дунд буюу өрхийн үйлдвэрлэл хэрэгжихэд ямар ч асуудал байхгүй. Эрдэнэтэд бэлээхэн байгаа инженер, технологийн шийдлийг Булганы мал аж

ахуй, газар тариалангийн салбарт хэрэгжих өрхийн үйлдвэрлэлийн төсөлд ашиглавал Булганы малчин өрхүүд хангалуун амьдрах бүрэн боломжтой. Гэх мэтээр биенээ нэхсөн бүтцээр буюу кластераар хөгжих бүрэн боломж хойд бүсэд бий.

**Хойд бүсээрээ өрхийн  
үйлдвэрлэл явуулж, иргэн  
бүр нь ажилтай орлоготой  
амьдрах боломжтой гэсэн  
үг үү?**

**" Асуудлын гүнийг  
мэдрээд ирэхээр  
хүнтэй хүнлэг  
харилцахаас бүх  
зүйл эхэлдэгийг  
ойлгож мэдэрдэг нь  
амьдралын жам, хууль  
шүү дээ.**

Хойд бүсэд тийм боломж бий. Хамгийн гол нь иргэддээ боломж олгох ёстой. Таван хошуу мал энэ уур амьсгалд хэдэн сая жил амьдраад дасан зохицоод ирсэн. Таван хошуу малыг нүүдэлчид гаршуулахад багаар бодоход 100 мянган жил зарцуулсан гэдэг байх шүү. Товчондоо, байгалийн зүй зохицлогоор өдий хүрсэн тул бэлчээрийн мал аж ахуйгаа техник технологийн дэвшилтэй уялдуулж, инновац шингээх замаар хөгжүүлэх нь зүйтэй. Хэрвээ хөдөө аж ахуйн парктай болчихвол түүхий эдийн татан авалт, анхан шатны гүн боловсруулалт сайжирна. Мэдээж хамгийн гол нь хамтдаа хөгжихийн тулд бүгдээрээ нэг цонхаор хардаг байх хэрэгтэй. ■



“ Өнөөдөр монгол хүнээс та эх орондоо хайртай юу гэж асууж болохгүй. Асуувал жинхэнээсээ доромжилсон болно. Учир нь эх орондоо хайргүй монгол хүн гэж байдаггүй юм.

# Эн түрүүнд ҮЗЭЛ САНАА

Энэ бол асар их  
эрч хүч.

Даанч жаахан хаос маягтай. Нийгмийн сүлжээг ийм эмх цэгцгүй эрч хүч хуйлруулж, гудамж талбайг ийм эрч хүч донсолгож байна. Монгол улсаа ингэж ч хөгжүүлье, тэгж ч мандуулъя гэсэн үг өгүүлбэр, санаа оноо хахаж цацаастай. Зарим нь харааж зүхнэ, зарим нь халаглаж харуусна. Уг нь энэ их эрч хүчийг нэгэн зүгт

чиглүүлж чадвал хөгжил өөрөө асар их дотоод түлхэцээр цэнэглэгднэ.

Монгол улсын хөгжил бол том үйл хэрэг. Нийгмийн эрч хүчийг цогц үзэл, өөрөөр хэлбэл үзэл санаагүйгээр дайчлах нь зүгээр л наймаа болдог. Явцуу ашиг сонирхолд хүлэгддэг учраас тэр. Зөвхөн тогоо шанага хангинуулсан, хоол унд шиншилсэн зэр зэвсэггүй арми инээдэмтэй харагдана. Түүнтэй адил зөвхөн эдийн засаг шүтсэн, үзэл санааг умартсан улс ч бас өрөвдөлтэй. Өнөөдөр үзэл санааг нийгмийн сүлжээн дээр хувь хүний пост, сэтгэгдэл, шэйр мэт төсөөлөх болж, хөөрхийс. Тийм биш. Нийгмийн сүлжээгээр шаагилдаж “сэвдэг” олон асуудлаас илүү чухаг нандин зүйл бидний сэтгэлийн гүнд уяатай байдаг тэр бол угтаа УЗЭЛ САНАА. Үзэл санаа гинжин урвалд орж гэмээн хүч болдог. Бид бусдаас илүү ч биш, бас дутуу ч биш. Бид бусдаас илүү гэвэл үндсэрхэг үзэл, бусдаас өөр гэвэл үндэсний үзэл юм. Энэ бол Монгол улс, монголчууд Үндэсний ардчилсан үзэл санаатай байх хангалттай үндэслэл мөн.

Ардчилал бол зэв ашиглавал боломж, буруу хэрэглэвэл завхрал болдог механизм болохоос үзэл санаа биш. Хуурамч ардчилал, ориг ардчилал гэж ч байхгүй. Энэ бол хуурамч ардчилагчдын замнаалаа уртасгах гэсэн заль мэхээс өөр юм биш. Ардчилал байдгаараа л байгаа. Түүний үнэт зүйлийг алдагдуулалгүй улс, үндэстнийхээ онцлогт тааруулан хэрэглэх тухай ярих нь тулгамдсан асуудал,

үзэл санааны суурь хэмжүүр. Өөрөөр хэлбэл, Үндэсний ардчиллын тухай үзэл санааг дэвшүүлэх, хөгжүүлэх, хэвшүүлэх нь жинхэнэ Үзэл санаа юм. Малгай хэрэггүй гэж ам ангайгаагүйтэй адил ардчилал хэрэггүй гэж хэлээгүй, хэлэх ч ёсгүй. Сэм авгай бортогон малгайтай, араб эр алаг эрээн алчууртай, хятад хүн тоорцготой.

Тэгвэл үзэл санаа гэж юу юм? Энэ бол тухайн объектын мөн чанар, үйл ажиллагааны шинж чанарыг тодорхойлогч үндсэн зарчим юм. Монгол улс, Монголчуудын мөн чанар, үйл ажиллагааны зарчим юугаар тодорхойлогдох вэ? Монгол улс, монголчуудын язгуур эрх ашгаар л тодорхойлогдоно.

Энэ эрх ашгийг төр хангаж өгдөг, баталгаа нь болдог.

Монгол төрийн үзэл санаа, Монголын үндэсний ардчиллын үзэл санаа бол нэг л юмны хоёр тал.

Үүнээс өөр байх ямар ч аргагүй. Тиймээс ч үндэсний ардчиллын үзэл санааг илүү том дэвсгэр дээр харах, бүсчлэн хөгжихийн тулд Монголын төр Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хувилбарыг тун нягт судлаж боловсруулахын зэрэгцээ төрийн залгамж чанар, сонгуульт шинж чанар хоёрын зохиц харьцааг хадгалах үүднээс УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоотой томсгосон тойгоор явуулах эрх зүйн шинэttгэлийг хийгээд байна.

Энэ бол мөнөөх л үндэсний ардчиллын үзэл санаа руу дөтлөж буй бодит алхамууд мөнөөсөө мөн.

Бидэнд байгаа цорын ганц нандин юм бол эх орон.

Бидэнд буй цорын ганц үнэт зүйл бол эх орон маань. Тийм учраас монгол хүнээс та эх орондоо хайртай юу гэж асууж болдоггүй юм. Цочмог уурлаж, түргэн бачуурдаг юм. Эх орондоо хайргүй монгол хүн гэж байхгүй. Харин эх орноо хайрлахад хэр ухаан зарав гэвэл бодлогоширч магадгүй. Энэ бодлогошироос л оюун санааны сэргэлт ивэлнэ.

Эхлээд сайн, муу гэдгээ сайтар ялгаж авалгүйгээр бүх сайн сайхан юмны төлөө эсвээс бүх муу муухай юмны эсрэг тэмцэх боломжгүй. Үүнийг үзэл санааны хүрээнд л тогтооно. Үзэл санаа биднийг бусдаас ялгаруулж урагш хөтлөж, ёс зүй, ёс суртахууныг тодорхойлох ёстой. Энэ үзэл санаа нийгмийн амьдралын суурь, хөдөлгөгч хүч, түг далбаа болох ёстой. Яагаад гэвэл бид нэг цул язгуур эрх ашигтай нэг цул үндэстэн.

Би УИХ-ЫН ГИШҮҮН Д. Батлутыг арван хуруу шигээ мэднэ гэж хэлэхгүй. Гэхдээ хааяа таван үг сольдог, ганц нэг ярилцлага хийж байсан нь гарцаагүй үнэн. Таван үгэндээ танигдана гэж ярьдаг. Үзэл бодлоос нь үзэл санааг нь тандана, томъёоллын хэмжээнд зангидана гэвэл дээрхи үгийг л хэлэх байна даа. Ингэж батлах үндэслэлийг тэр хангалттай надад үлдээжээ. Би түүнийг үзэл санаатай, тэр үзэл санаандаа үнэнч хүн гэж хэлнэ. ■

Б. Баттогтох



**УИХ-ЫН ГИШҮҮН Д.Батлут  
ОНЦЛОХ ЭШЛЭЛ**

УИХ-Д ТҮМНЭЭ ТӨЛӨӨЛӨН СУУГАА ТӨРИЙН ТҮШЭЭДИЙН ҮНДСЭН АЖИЛ НЬ ХУУЛЬ САНААЧЛАН БОЛОВСРУУЛАХ ЯВДАЛ. КАМЕР ХАРАН ХЭЛД ОРЖ, КНОП ДАРАН СУУДАЛ БӨГЛӨГСӨӨД Ч ӨНӨӨГИЙН ПАРЛАМЕНТ ТӨДИЙГҮЙ ӨМНӨХӨД НЬ БАЙСНЫГ БИД МЭДНЭ. ХАРИН ЭРДЭНЭТИЙН ГЭХ ТОДОТГОЛТОЙ Д.БАТЛУТ ГИШҮҮН ХЭВЛЭЛИЙНХНИЙ ХУВЬД ХААЛТТАЙ ГЭГДДЭГ Ч ХИЙЖ БҮТЭЭСНЭЭ НҮҮР НОМООРОО ТАЙЛАГНАЖ ХЭВШСЭН ИЛ ХҮН АЖ. ЭРХЭМ ГИШҮҮНИЙ ХЭВЛЭЛД ӨГСӨН ЦӨӨН ЯРИЛЦЛАГУУДААС ТОЙМОЛОХОД ИЙМ БУЮУ. ТЭРБЭЭР ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ПАРКАД МОНГОЛ ТЕХНОЛОГИЙГ ШУУД ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛГОЖ ХУВИРГАХ ХЭРЭГТЭЙ. МОНГОЛ ИНЖЕНЕРҮҮДИЙНХЭЭ ТОЛГОЙГ АШИГЛАЖ ЧАДВАЛ ЭНЭ ДЭЛХИЙН ХӨГЖИЛД АТААРХАЖ БУС АРААСАА ДАГУУЛАХ ЦАГ ОЙРХОНДОО ГЭХ ЮМ БИЛЭЭ.

## Эрдэнэт бол инженерүүдийн хот

Монгол Улсын хөгжлийн гол цөм нь эдийн засгийн хөгжил юм. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар ХОЙД BYC гэдэг нь Орхон, Хөвсгөл, Булган аймаг. Эрдэнэт хот бол инженерүүдийн хот. Өнгөрсөн жилүүдэд бид нөөцдөө тулгуурлаж Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн паркыг байгуулсан. Үр дүнгээ ч өгсөн. Энэ туршлагаараа Булган, Хөвсгөлд тохирсон технологи, инновацын шийдлүүдийг гаргаж нутагшуулбал ЖДҮ-д бойжиж, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болж бус нутаг бие дааж хөгжих боломж нээгдэнэ. Эрдэнэт хотод ч Хөвсгөл, Булган аймгийн давуу чанаруудыг нутагшуулах бүрэн

боловсруулж, санаачлахад оролцоо, эрхийг тодотгож өгсөн. Энэ заалт хэр оновчтой гэж та үзэж байна вэ?

"Монголын эдийн засгийн чуулган 2024-Бүсчилсэн хөгжил" чуулган 2024.02.02

## Хуулийн ач холбогдлыг иргэд бодит амьдрал дээр хүртэхийн тулд өөрсдөө идэвх, санаачлагатай байх хэрэгтэй

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэлээр нутгийн өөрийн

удирдлагад иргэний оролцоо оролцоо, эрхийг тодотгож өгсөн. Энэ заалт хэр оновчтой гэж та үзэж байна вэ?

Нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангана гэдэг маш чухал. Тухайлбал, "Сум, баг, дүүрэг, хорооны тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй" гэж иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг орон нутгийн өөрөө удирдах удирдлагын тогтолцоотой холбон тодорхой илэрхийлж хуульчлан суулгаж өгсөн. Бас нэгэн чухал зохицуулалт бол "Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй" гэж тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн амьдралд үгүйлэгдэж байгаа асуудлыг иргэд өөрсдөө санаачлах, хэлэлцэж шийдвэр гаргуулахаар хандах эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн. Энэ бол үнэхээр дэвшилттэй шинэлэг зохицуулалт болсон. Үүний ач холбогдлыг иргэд бодит амьдрал дээр хүртэхийн тулд энэ эрх зүйн орчинг бүрэн ашиглаж өөрсдөө идэвх, санаачлагатайгаар оролцох хэрэгтэй юм.

Vip76.mn /2021.12 сар/

**“Эрдэнэт”  
үйлдвэрийг  
түшиглэсэн  
үйлдвэрүүд  
2025 оноос  
ээлж дараалан  
ашиглалтад орно**

**Та УИХ-д нэр дэвшихдээ  
Эрдэнэт хотыг “ухаалаг хот”  
болгох төслийн талаар ярьж  
байсан. Хэрэгжилт ямар  
шатандаа байгаа вэ?**

Засаг даргаар ажиллаж байхдаа Анх удаа Эрдэнэтэд Шинжлэх ухаан, технологийн паркийг байгуулсан. Улсын хэмжээнд жишиг болохуйц энэ асуудалд Монгол Улсын Засгийн газраас онцгой анхаарч, бодлогоор дэмжин Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг УИХ-д оруулах гэж байна. Шинжлэх ухаан технологийн ололт, монгол технологийг шуд үйлдвэрлэл болгож хувиргах хэрэгтэй. Улс, бусийн хөгжлийн төвүүд импортлогч биш экспортлогч болох хэтийн зорилго руугаа хандан ажиллах хэрэгтэй.

Montsame.mn /2021.06.17/

**Аль болох олон  
хүний амьдралыг  
эергээр өөрчлөх  
гэж л шийдвэр  
гаргах түвшинд  
ажиллаж байна**

**Амжилт гаргахад хамгийн чухал зүйл юу вэ?**

Амжилт гаргахад нэг зорилготой баг, хамт олон их чухал. Нөгөө талаас

хүрэх зорилго, төлөвлөгөө тодорхой байх ёстой. Би ажил, амьдралдаа “Хүн байх нь чухал” гэдгийг л мөрдлөг болгодог. Хүн хүнээ хүндэтгэж, хайлраж явах сайхан шүү дээ. Амьдрал ямар үүрдийнх биш. Хорвоод амьдрах богинохон хугацаандаа “хүн”-ээрээ байхыг л хүсэж явдаг.

**Таны хувьд манлайлагч хүн ямар байх ёстой гэж боддог вэ?**

Манлайлагч хүн бусдын жаргал, зовлонг ойлгодог байх ёстой. Өөрийн төлөө биш бусдын төлөө шийдвэр гаргадаг байх ёстой. Зарим үед өөрийгөө золиосолж чаддаг байх хэрэгтэй. Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа манлайлагч хүн энэ ажлыг хийснээр, ийм шийдвэр гаргаснаар үр дүн нь бусдад яаж нөлөөлөх бол гэж хамгийн түрүүнд бодож үздэг байх хэрэгтэй. Аль болох олон хүний амьдралыг эергээр өөрчлөх гэж л шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа шүү дээ.

Улстөрч сэтгүүл 2020.09.09

**Уул уурхайн баялаг  
төрд очсоны ашиг  
шиимийг иргэд  
хүртлээ**

Сүүлийн гучин жилд төр бол хамгийн муу менежер гэдэг тархи угаалт их явсан. Тэгтэл төр хүсэх юм бол хамгийн сайн менежер байж чадна гэдгийг өнөөдөр “Эрдэнэт” үйлдвэр харууллаа.

Тэгэлгүй яахав. 2016 оны сонгуулиар зургадугаар сарын

21-нд тухайн үед Ерөнхий сайд байсан Ч.Сайханбилэг шийдвэр гаргаад Эрдэнэт үйлдвэрийн ОХУ-ын 49 хувийг Монголын компани авсан, одоо Монголын 100 хувийн өмчт компани боллоо гэж зарласан. Тэрнээс хойш улс, орон нутгийн төсөвт хэдэн төгрөг төлж байсан гэж та бодож байна. 2016 онд 184 тэрбум төлсөн. 2018 онд Монгол Улсын Засгийн газар шийдвэр гаргаад 100 хувь төрийн өмчт үйлдвэрийн газар болгоно гээд онцгой дэглэм тогтоосон. Ингээд ажиллангуут 2018 ондоо 560 тэрбум, 2019 ондоо 960 тэрбум, 2020 онд 1 их наяд төгрөг улсын төсөвт төвлөрүүлж байгаа юм.

Цар тахлын үед Эрдэнэт үйлдвэрийн ашгаас 650 тэрбум төгрөг гаргаад иргэдийнхээ амьжиргааны түвшинг бууруулахгүйн тулд эрчим хүчнийх нь бүх зардлыг долдуугаар сарын 1 хүртэл төр даалаа. Энэ бол уул уурхайн баялаг төрд очсоны ашиг шим. Энэ бол шударга ёсонд нийцнэ. Шударга ёс руу бид бүхэн тэмүүлдэг.

Ikon.mn /2021.06.07/

**Дарга дагуулсан  
төсөв битгий  
оруулж ирээч ээ**

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн санхүүжилт буюу энэ зээлээр хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх ёстой. Алсын хараа 2050-д сууринсан томоохон хөгжлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх

ёстай. Улс, орон нутгийн төсвөөр хийчихээр ажлыг зээлээр санхүүжүүлж болохгүй. Энэ хөтөлбөрт 17 аймаг оржээ. Төсвийн гол ачаалал авдаг аймгуудыг хассан байна. Ийм бодлого байж болох уу. 735 сая доллар бол асар их мөнгө. Дэд бүтэц болон бизнес эрхлэгчдийг дэмжих хэрэгтэй. Гэтэл хүн ам олонтой ч хасагдаад буй аймгуудад санхүүжилт маш хэрэгтэй байна. Бүх зүйлээс хасагдаж ормооргүй байна. Орхон аймаг болон бусад улсын төсөвт орлого оруулдаг аймгуудаа дэмжих ёстай. Дарга дагуулсан төсөв битгий оруулж ирээч ээ. Аймгуудаа жигд дэмжих ёстай.

УИХ-ЫН ЧУУЛГАНЫ /2023.07.06/-НЫ  
ӨДРИЙН ХУРАЛДААН

## Зах зээлийн зарчмаараа биш илүү хямд үнээр нүүрс нийлүүлэх нь гэж уншигдаад байна

Уул, уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг батлаад удаагүй байна. Энэ хуулийн үйлчлэлээр Монгол Улсын эдийн засагт томоохон өөрчлөлт орсон. Нэг ёсондоо төсөвт нэмэх оног авчирсан хууль болсон. “Уул, уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд, төрийн өмчийн хуулийн этгээдийн борлуулах уул, уурхайн бүтээгдэхүүнийг заавал биржээр арилжих зохион

байгуулалт хөндөгдсөн. УИХ-ЫН 68 дугаар тогтоолд тусгайлан дурдсан худалдан авагчтай урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авахтай холбоотой харилцааг уул, уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиар зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна. Үүнийг уншинггуут зах зээлийн зарчмаараа биш илүү хямд үнээр нүүрс нийлүүлэх нь гэж уншигдаад байна. Хууль баталж гаргаад, хэрэгжүүлэх гээд буйн утга санаа нь алдагдаад байна. Хуулийн хүчин чадал нь буураад байна. Төрийн бодлого ч тогтвортгүй байх төлөвтэй. Алсдаа “Нүүрс 2” гэх хэрэг гарах вий.

УИХ-ЫН НЭГДСЭН ЧУУЛГАН 2023.10.19



Солийн  
Данзангийн  
тэрсүү  
үг ба **хойд  
бүсийн  
хөгжлийн  
нууц**

УИХ-ын гишүүн Д.Батлут



Том улстөрчдийн алдартай эшлэлүүд алийг тэр гэхэв. Миний хувьд нэг эшлэл гойд санагддаг юм. Ардын хувьсгалыг эхлүүлсэн анхны долоогийн нэг Солийн Данзангийн “Иргэн бүр баяжигтун” хэмээх үг. Ингэж хэлснийхээ төлөө мань эр тухайн үедээ буруутаж, хэлсэн уриа нь цагийн салхинд бүдгэрсэн нь түүхийн гашуун үнэн. Ерэн оны ардчилсан хувсгалын дараахан “иргэн бүр баяжих нь ээ” гэсэн олзуурхал хүн бүрийн зүрхэнд ассан ч нийт баялгийн дийлэнх хувийг цөөнх нь

хүртсэн нийгэмд улсаараа бүдчиж явна. Товчхондоо бид Данзангийн тээр жил хэлсэн тэрсүү үгийн үнэ цэнийг бүтээж чадаагүй явна. Улстөрчийнхөө хувьд хүрч мэдрэгдэхээр зүйл хийх юм шүү гэж хорхойсон хөөцөлдөж яваа ганц том өнцөг л дөө, энэ. Иргэн бүрээ баяжуулахсан. Улстөрч болгон ийм бодолтой ажиллавал болохгүй юмгүй өнцөг. Солийн Данзангийн мөрөөдлийг ажил болгох том суурь нь хүн гэж би хардаг. Хүнээ хөгжүүлж чадвал улсаараа баяжих холын мөрөөдөл биш.

Хүнээ хөгжүүлэхийн эхний гарц нь ерөөсөө л өрх бүрээ үйлдвэрлэгч болгох. Өрх бүр үйлдвэрлэгч байх бүрэн боломж бийг Орхон аймгийн Засаг даргаар ажиллах үедээ нотолчихсон учраас ингэж ам бардам хэлээд байгаа хэрэг. Би Орхон аймгийн Засаг дарга байхдаа хүүгүй, барьцаагүй, таван сая хүртэлх төгрөгийг иргэдэд зээлдүүлэх ажлыг эхлүүлсэн юм. Итгэлцэл дээр суурилсан энэ харилцаа өдгөө маш амжилттай яваа. Мэдээж бүх зүйл хуулийн гарц, шийдэл дор өрнөх учиртай. Бидний шийдэл



МАН-ы анхны дарга Солийн Данзан, 1922

бол гарааны төслийдийг бойжуулах зорилгоор байгуулсан Шинжлэх ухаан, технологийн парк байсан юм. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй хүмүүс энэ газарт хандаж, хүүгүй, барьцаагүй зээлд хамрагдсан гэсэн үг. Олзуурхмаар нь иргэдийн хүү, барьцаагүй авсан зээлийн эргэн төлөлт 90 гаруй хувийн төлөлттэй явaa. Цагаа мэдэрсэн, итгэлцэл болоод судалгаан дээр суурилсан шийдлийн өгөөж ийм сайхан.

Энэ ажлаа илүү үр дүнд хүргэх гарц бүрийт эрж хайж,

хорхойсч ажилласан өнгөрсөн хоёр жилд гэхэд л 1000 гаруй айлаар орж санаа оноог нь сонсчээ. Заримд нь жижиг тоног төхөөрөмж хөөцөлдөж олж өглөө. Төрийн ашиглахгүй хаягдсан байшин барилгыг сэргээн засварлаж бичил үйлдвэрлэл эрхлэх zaluuug үйлдвэрийн байртай болоход нь дэмжлэг үзүүллээ. Ажиллах, мөнгө олох боломжийг нь энэ мэтээр нээж, дэмжээд байвал жижиг бизнесүүд ямар голоо цэцэглэдгийг харж мэдэрсэн учраас 2000 гаруй хүнийг хэрэгтэй тоногтой төхөөрөмжөөр нь дэмжих

гэж байна. Ногоогоо тарих нь тариг, эсгий углаашаа хийх нь хийг, бэлэг дурсгалын зүйл урлах нь урлаг. Эрдэнэтэд маань лаа хийдэг нэг бусгүй бий. Зүсэн зүйлийн хэлбэртэй лаа урладаг тэр бусгүйтэй үзэсгэлэн худалдааны үеэр танилцсан юм. Гэртээ хүүхдээ харангaa хоббигоо бизнес болгосон сэдэл хандлага нь таалагдаад хүү, барьцаагүй зээлээрээ багахан дэмжлэг үзүүлсэн чинь одоо яасан гээ. Шимиийн архийг хачин голоо савлагатайгаар зах зээлд нийлүүлээд эхэлчихсэн. Ганц Эрдэнэтэд

ч биш Улаанбаатарын том зах, дэлгүүрт тэр бүсгүйн үйлдвэрлэж буй шимиийн сархад худалдаалагдаж байна. Хоёр жилийн өмнөх цагаан сараар айлуудын тавгийн идээний голд тавьдаг арван хоёр жилийг шоколадаар урлаж худалдаад 20 сая төгрөг олсон адтай бүсгүй л дээ. Хүн бүрд түүн шиг гэртээ бичил бизнес эхлүүлээд амьдралаа аваад явах чин хүсэл бий. Зээлээр, ажиллах бойжих орчиноор дэмжээд өгвөл сэвхийгээд явчихдаг кейсүүд жагсаавал өчнөөн байна. Төр иргэддээ энэ мэт боломж олгоод байвал өрхийн үйлдвэрлэл цэцэглээд л байна. Өмнөд Солонгос, Япон гэх мэт хөгжлөөрөө цойлж буй улс яг энэ жишгээр урагшилсан. Иргэд нь тус бүрдээ жижиг бизнес цэцэглүүлж, тэр дундаас том корпорациуд нь төрж, өнөөгийн хөгжлөө

бүтээж чадсаныг мэргэн уншигч та надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа.

Эрдэнэтэд хэрэгжүүлсэн энэ шийдлээ хэрхэн улсын хэмжээний ажил болгох вэ гэсэн асуултыг өнгөрсөн жилүүдэд өөртөө их олон удаа тавьж байлаа. Эцэст нь хариултаа олсноо тантай хуваалцъя. УИХ жижиг дунд болоод бичил үйлдвэрлэлийг дэмжье гээд хууль баталсан ч бичил бизнес эрхлэгчид тойргийн гадна гээгдсээр өнөөг хүрээд буй. Жилийн эргэлт нь 300 саяар хэмжигдэх хүмүүсийг бичил бизнес эрхлэгч гэсэн ангилалд багтаачихаар ямар ч өрхийн үйлдвэрлэгч хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлд хамрагдах боломжгүй нь тов тодорхой зүйл. Энэ алдааг олж хараад санаачилсан хууль маань батлагдвал жилийн эргэлт нь

цөөхөн төгрөгөөр эргэлддэг бичил бизнес эрхлэгч иргэдэд, өөрөөр хэлбэл юм хийж амьдралаа өөд татах сэтгэлтэй хүн бүрд хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авах боломж бүрдэнэ.

Өнгөрсөн жилүүдээ эргээд хархааар өрх бүрийг үйлдвэрлэгч болгохын тулд Орхон аймгийнхаа хэмжээнд чамгүй их ажил амжуулчихаж. Ер нь ямар ч ажлын үр дүн нүдэнд харагдаж гарти баригдаад ирэхээр илүү томруулах, хүрээг нь тэлэх хүсэл оргилдог нь жам юм шиг. Хүн бүр хийж амжуулж яваа ажилдаа ингэж шунан шимтдэг. Тэгж шунан шимтдэг учраас амжилт, хөгжилд хүрдэг гэчихэд дэгсдүүлсэн дүгнэлт болохгүй. Уншигч та ч энэ үнэнийг амьдралаараа батлаад явж байгаа гэдэгт эргэлзэх зүйл алга. Миний



Хутаг-Өндөр сум, Булган аймаг

ХӨВСГӨЛ·БУЛГАН·ОРХОН

# Хаштгалаа





Хорьдол Сарьдагийн нуруу, Хөвсгөл аймаг

ирэх жилүүдийн "шунал" бол Хөвсгөл-Булган-Эрдэнэт гэсэн алтан хослолыг бий болгох. Өөрөөр хэлбэл хойд бүсийн эдийн засгийг өрхийн үйлдвэрлэлээр дамжуулж сэвхийлгэх. Онцгойлж олзуурхмаар нэг тод өнгө энэ гурван аймагт бий. Тэр нь эдгээр гурван аймгийн өөр өөрийн гэсэн ялгарал. Булган аймаг мал аж ахуй, тариалантай, харин Хөвсгөл аялал жуулчлалын том орон зай. Эрдэнэтийн хувьд инженерүүдийн хот. Таван хүн тутмын нэг нь инженер учраас техник, технологи өндөр хөгжсөн. Энэ онцлогийг нь олж хараад Эрдэнэтээ Монголын цахиурын хөндий болгох зорилго, мөрөөдөлтэй зүтгэж яваа. Ийм ялгарал нь биесээ нөхөж, хойд бүс тун ойрын хугацаанд

эдийн засгийн өрсөлдөх чадвараараа толгой цохино гэдэгт эргэлзэггүй.

Булган аймгийн Могод сум гэхэд айргаараа алдартай. Могодынхон айргаа тусгай шошготой цэвэр усны саванд савлаад зарж эхэлсэн нь бас л хөөрхөн санаа. Өрхийн бизнес энэ мэтээр хөгжиж байж хүрээгээ тэлнэ. Өрхийн үйлдвэрлэл хүрээгээ тэлэх хэрээр стандарт гэдэг асуудал сөхөгдөж таарна. Стандарт, хяналт гэхээр Мэргэжлийн хяналт гэж ойлгох нь тийм ч зөв гарц биш. Хөгжингүй улсуудын тухайд иргэд нь зах зээлдээ үнэлгээ өгдөг систем ажилладаг. Тусдаа платформ үүсгэж өгөх нь л төрийн үүрэг. Тэр платформ дээр иргэд үнэлгээ өгөөд явчихна. Жишээ нь Булганы Могодын

айргийг авч уусан хэрэглэгч тэр платформ дээр сэтгэгдлээ үлдээнэ, тэр сэтгэгдэл тухайн үйлдвэрлэгчийн үнэлгээ болоод явчихна гэсэн үг. Энэ мэт олон санаа шийдэлд хариу олоод явчихвал "хойд бүсийн алтан гурвал" цэцэглэх бүрэн боломжтой.

Эрдэнэтийн үйлдвэрлэл технологи Булганы мал аж ахуй, Хөвсгөлийн аялал жуулчлалд нэвтэрч, Эрдэнэт Хөвсгөлийн аялал жуулчлал, Булганы хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний том зах зээл болж гээд яривал биенээ нөхөж хөгжих түмэн давуу тал хойд бүсэд бий. Өрх бүр үйлдвэрлэгч байх боломжийг олоод харчихсан шийдэл маань хойд бүсийн энэ "алтан давуу тал" дээр цэцэглэнэ гэдэгт эргэлзэх зүйл алга. ■



УИХ-ЫН ГИШҮҮН  
Д.Батлутын 2020-  
2024 онд ажилласан  
хууль, тогтоолын  
төслүүд болон хууль  
тогтоогчийн хувьд  
хэрхэн ажилласныг  
нь тоймлон хүргэе.


Гишүүнээр нь ажилласан  
байнгын хороод:

**Эдийн засгийн  
байнгын хороо**

**Үйлдвэржилтийн  
бодлогын байнгын  
хороо**

**Нийгмийн бодлогын  
байнгын хороо**

**УИХ-ЫН ГИШҮҮН  
Д.БАТЛУТ 2020-2024**



## Оролцоотой ажилласан Ажлын хэсгүүд

2020-2024 он хүртэл Монгол Улсын Засгийн газрын 2020-

2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын хөгжлийн банкны асуудлаарх УИХ-ЫН хянан шалгах түр хороо, Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих ажлын явцыг

эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг гэх мэт нийтдээ 20 ажлын хэсэгт орж ажиллав. Эдгээрээс 3 ажлын хэсгийг нь ахлалаа.

# Хууль тогтоол

## Өргөн мэдүүлж, батлуулсан хуулиуд

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйл байдлын тухай хууль
- Нийгмийн даатгалын шимтгэлийг 2 хувиар бууруулах хууль
- Зөрчлийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл сүутган төлөх хууль

## УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

- Хүний эмийн асуудлаарх хянан шалгах түр хороо байгуулах тухай
- Малын эрүүл мэнд, мах, түүхий эдийн үйлдвэрлэл, экспорт, Биокомбинат ТӨХХК-ийн өргөтгөл шинэчлэлийн асуудлаар шалгалт хийн, дүнг УИХ-ЫН чуулганы нэгдсэн

хуралдаанд танилцуулах, санал боловсруулах үүрэг бүхий хянан шалгах түр хороо

## Өргөн мэдүүлэхээр зэхэж буй хуулийн төсөл

- Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулав. Одоогоор parliament.mn сайтад байршуулан олон нийтээс санал авах ажил үргэлжилж байна.

# Тусгасан санал

## “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан саналууд:

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай-

- металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах.
- “Эрдэнэт хотын шинжлэх ухаан технологийн паркийг загвар болгон хөгжүүлэх”.
- “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт 92.28 км хатуу хүчилттай авто зам төсөл” хэрэгжүүлэх.
- “Шинжлэх ухаан,

- инновацийн төвийн кластерын байршилд Улаанбаатар хот гэсэн дээр Орхон аймгийг нэмэх”
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд амьдрах ээлтэй орчин бүрдүүлэх”
- “Хөрсний бохирдол бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх”

## Гадаад харилцаа

- Монгол-Австрали, Монгол-Албани, Монгол-Америкийн парламентын бүлэгт ажиллав.
- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНСВУ-д хийсэн айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллалаа. Монгол Улсын иргэд Вьетнамд визгүй зорчилоор болсон нь уг айлчлалын нэг том үр дүн байв.
- АНУ-ын ЭСЯ-ны олон нийттэй харилцах албаны дарга Жон Брауныг төрийн ордонд хүлээн авч уулзахдаа Америкийн соёл мэдээллийн төвийг Эрдэнэт хотод байгуулах талаар санал солилцов. Уг яриа өдгөө ажил хэрэг болж, Эрдэнэт хотод Америкийн соёл мэдээллийн төв үүдээ нээх гэж байна.
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхайн металлург, химийн
- Үйлдвэрийн цогцолбор байгуулах амлалт ажил хэрэг болов. БНСУ-ын баг Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн Үйлдвэр, технологийн паркийн талаарх судалгааг хийж дуусгаад байна.
- Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 92.28 км авто замын төслийг Европын сэргээн босголт хөгжлийн банк санхүүжүүлэхээр болов.



## Онцгойлон анхаарч ажилласан салбар

### Эрүүл мэнд-нийгэм

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт, эрүүл мэндийн даатгалын сангийн эрх зүйн орчин, эрүүл мэндийн салбар дахь гүйцэтгэлийн санхүүжилтыг боловсронгуй болгохтой холбоотой УИХ-аас байгуулагдсан дөрвөн ажлын хэсэгт ажиллав. Эдгээр ажлын нэгээхэн үр дүн гэхэд л өрхийн эмнэлгийн эмч, ажилтнуудын цалин тодорхой хувиар өсч, өрхийн эмнэлгүүдийн санхүүжилт хоёр дахин нэмэгдэв. Өрхийн эмнэлгүүд иргэдэд үйлчилсэн хүртээмжээрээ санхүүжилтээ

шийдүүлэхээр болсон нь иргэдэд өгөөжөө өгсөн шийдэл болсон билээ.

### Эдийн засаг

Эдийн засагт том нөлөө үзүүлэх хэд хэдэн хуулийн төсөлд оролцоотой ажилласны нэг нь Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хуулийн төсөл байв. Д.Батлутын санаачилсан уг хуулийн төсөл батлагдсанаар өдгөө Эрдэнэт үйлдвэрийг түшиглэж Аж үйлдвэр, технологийн парк байгуулагдах нь тодорхой болж, бүтээн байгуулалтын ажил нь эхлээд байна.

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2020-2024

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө

Улсын төсвөөс

**110,042,000,000 ₮**

Бусад эх үүсвэрээс

**215,554,300,000 ₮**

Боловсролын салбарт

**32.5** тэрбум  
төгрөг

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нэмэгдэж 93,7 хувьд хүрч байна

Эрүүл мэндийн салбарт

**7.08** тэрбум  
төгрөг

Анхан шатны эмнэлэгийн санхүүжилт өсч 307.08 тэрбум төгрөг боллоо

Нийгэм хамгаалал

**68.3** тэрбум  
төгрөг

Дэд бүтцийн салбарт

**217.6** тэрбум  
төгрөг

Дээрх санхүүжүүлэлтээр бодит болсон төслүүд нь олон их наяд төгрөгийн үр өгөөжийг цаашид өгнө.



# 2021-2024 онд батлагдсан ОНЦЛОХ 9 ХУУЛЬ

Хууль боловсруулах үйл ажиллагааны эзэд нь нэг талаас хуулийн төсөл боловсруулагчид, нөгөө талаас хуулийн захиалга өгсөн бодлого тодорхойлогч байдаг. Өөрөөр хэлбэл төрийн түшээд түмний төлөөлөл болон УИХ-д суудаг гэсэн үг. 2020-2024 онд түшээд түмний төлөөлөл болон ажиллахдаа баталсан олон зуун хуулиудаас есийг онцлоё.

## 1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав

- Энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, нотолгоонд үндэслэсэн, чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй байна.
- Даатгуулагчид эрүүл мэндийн эрсдэл учирсан үед шаардлагатай тусламж, үйлчилгээний бүх зардлыг ЭМД-ын сангаас төлүүлэх бүрэн боломж бүрдсэн юм

## 2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

- Ажил олгогч ажилд орох гэж байгаа хүн болон ажилтнаас мөнгө, үнэ бүхий зүйл авахыг хориглоно.
- Ажил тэр тусмаа төрийн албандаа оруулах нэрээр авлига хээл хахууль авах явдал үүгээр бүрэн эцэслэгдсэн гэж үзэж болно.

## 3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

- Хуулиар нийслэл, дүүрэг, хорооны чиг үүргийг тодорхойлж, нийслэл, дүүрэг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санхүүжилт нь цуг байхаар зохицуулжээ. Мөн чиг үүргийн давхардалгүй байхыг зохицуулсан.
- Тус хуульд орон нутгийг бие даалгах, эдийн засаг, санхүүгийн үндсийг тодорхой болгох, улс төрийн хамаарлыг багасгах зэрэг шинэлэг өөрчлөлт оржээ.

## 4. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга

- Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага таван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тухай бүр сунгаж болох бөгөөд таван жилээс дээш хугацаагаар сунгахгүй.
- Согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд цахим орчин, холбооны хэрэгсэл, өөртөө үйлчлэх автомат машин ашиглан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хаягаар хүргэхийг хориглосноор архидалт 15 хувиар багасссан гэх статистик үзүүлэлт байна. Түүнчлэн бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардахыг хориглож, эрүүгийн хариуцлага хүлэлэгэх болсноор албан газрын архидалд 16 хувиар буурсан тухай Наркологийн үндэсний төв эмнэлгийн тайланд дурджээ.

## 5. Зөвшөөрлийн тухай хууль

- Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001) хүчингүй болж улмаар төрийн эрх бүхий байгууллагуудаас баталсан олон төрлийн журмаар зохицуулагдаж байгаа бүх тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг нэгтгэж нэгдсэн нэг тогтолцоо бий болов.
- Тухайн үед ойролцоогоор 914 тусгай болон бусад зөвшөөрөл байсан ч Зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр болсноор 363 болж багасах ба бизнес эрхлэгчдийн дарамт ачааллыг бууруулсан юм.

## 6. Тендер шалгаруулалтын бүх үе шат ил тод болов

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль шинэчлэгдсэнээр технологийн дэвшилд тулгуурлан тендер шалгаруулалт дахь хүний оролцоог бууруулж, тендерт оролцогчдын бүрдүүлдэг материалын зөвхөн 18 хувийг цахим хэлбэрээр төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн сангаас татан авч, тендерийн үнэлгээнд харгалзан үзэж байгааг 70 хувьд хүргэдэг боллоо.
- Тендерт оролцогчдын цахим мэдээллийн сан бүрдүүлж, компанийн мэдээллийн санд баталгаажсан мэдээллийг тендерийн үнэлгээнд ашигласнаар тендерт оролцогч ижил төрлийн баримт бичгийг олон дахин хувилж, тендер тус бүрд хүргүүлдгийг халсан юм.

## 7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Тэтгэврийн тухай хууль

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Тэтгэврийн Тухай хуулийг шинэчлэн найрууллаа.
- 2019-2023 онд тэтгэвэр тогтоолгоходоо б эсвэл 7 жилийн дундаж цалингаар тогтоолгосон ахмадууд өөрчлөх хүсэлтээ 2023 онд багтаан НДЕГ-т өгөх боломжтой болсон. Өөрчлөгдсөн тэтгэврийг 2024 оны нэгдүгээр сарын 1-нээс олгож эхэлсэн юм.

## 8. Нийгмийн даатгалын ерөнхий хууль

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нас барсан иргэний ар гэрт тэтгэврийн 20 хувийг өвлүүлэх заалт тусгасан.
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.6-д “Даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ” гэжээ. “Мөнгөжүүлсэн орлого” гэж тэтгэврийн даатгалын нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсгийг ойлгоно. Харин өв залгамжлагчид зөвхөн эхнэр эсвэл нөхрийг хамруулна.

## 9. Боловсролын багц хууль

- Багшийн нийгмийн хalamжид анхаарсан хэд хэдэн заалтыг багтаав. Тодруулбал Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анgid багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуульд 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багшийн 1 хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна. Амьдрах нөхцөлөө сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.



“ Миний хувьд монгол хүнийг эрүүл, баян байгаасай гэж хүсч, тэр орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллахыг илүүд үздэг. Тэр ч утгаараа эрүүл мэндийг хамгаалах өөрчлөх чиглэлд түлхүү анхаарч ажилладаг.

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Миний бие 2020-2024 онд УИХ-аар гишүүнээр ажиллахдаа орон нутгийн болоод хүний хөгжлөөс улсын хөгжил эхэлнэ гэсэн зарчмыг баримтлан ажиллалаа. Орон нутгийн хөгжлийн бодит эхлэл болсон авто замын бүтээн байгуулалтууд, иргэдийг ажилтай, орлоготой хангалийн амьдруулах үр дүнтэй шийдлүүдээ тоймлон хүргэж байна.

## | ЭРДЭНЭТ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2040 он хүртэлх Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна. УИХ-ын гишүүн Д.Батлут миний бие тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 2 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуйлаасаар хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил саадгүй үргэлжилж байна.

Бидний ирээдүй хүний төлөө, хамтын хөгжлийн төлөө байх болтугай. Эрдэнэт хүндээ ээлтэй Хүний төлөө бүтээгдсэн Алсын хараатай хот болон хөгжинө гэдэгт итгэлтэй байна.



## ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн орчин бүрдэж, Орхон аймагт “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрийн цогцолбор байгуулах тусгай зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн Газар олголоо. Хөгжлийн шинэ гарааг эхлүүлж буй тус төслийг хэрэгжүүлэхэд АИТХ дэмжиж 1217,4 га газрыг тусгай хэрэгцээнд авч өдгөө ТЭЗҮ боловсруулагдаж байна.

### Төслийн хүрээнд:

- **Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах төсөл**  
Хүчин чадал: Жилд 10 мянган тонн цэвэр зэс
- **Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр**  
Хүчин чадал: Жилд 124.1 мянган тонн зэс
- **Молибдений баяжмал боловсруулах төсөл**  
Хүчин чадал: Жилд 4.8 мянган тонн
- **Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр**

### Төсөл хэрэгжсэнээр өхний 20 жилийн үр ашиг

Орлого

**48** их наяд  
төгрөг

Шинэ ажлын байр

**1000** ажлын  
байр

Татвар

**1.4** их наяд  
төгрөг



## АЮУЛГҮЙ ХОТ, ШИНЭ ДЭД БҮТЭЦ

Урт хугацааны хэллэлцээрийн үр дүнд Эрдэнэт хотын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх зорилгоор зарцуулагдах хөрөнгийг ЕСБХБ болон Европын холбооноос татан төвлөрүүлэхээр боллоо.

**Нийт санхүүжилт: 14 САЯ ДОЛЛАР**  
**Үүнээс буцалтгүй тусlamж: 7 САЯ ДОЛЛАР**

**Далан:** 14 мянган метр куб  
**Бетон доторлогоотой суваг:** 1,9 км  
**Байгалийн суваг:** 23 км  
**Шинэ хоолой:** Нийт 15 хоолой  
**Дэд бүтцийн байгууламж:** Усны энерги унтраах 7 байгууламж



## 1000 ӨРХИЙН ОРОН СУУЦ

Монгол Улсын хамгийн олон хүн амтай сумд тооцогддог Эрдэнэт хот 24,450 өрхтэй. Сүүлийн үеийн судалгаагаар хүн амын тоо 100,000-д дөхсөн гэх. Тэр хэрээр орон сууцны эрэлт хэрэгцээ нэмэгдсээр буй. Тэгвэл Эрдэнэт хотын гэр хорооллын 1000 өрхийг орон сууцжуулахад шаардлагатай эхний инженерийн шугам сүлжээний зардлын санхүүжилтийг шийдвэрлэлээ.

**Шийдвэрлүүлсэн төсвийн хэмжээ:**  
**50 ТЭРБУМ ТӨГРӨГ**

**Хамрагдах багууд:**  
**Эрдэнэ:** 270 айл  
**Говил:** 270 айл  
**Үртын гол:** 240 айл  
**Их Залуу:** 240 айл  
**Цагаанчуулут:** 72 айл



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ПАРК

Эрдэнэт ШУТП нь зургаан үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэхээр ажиллаж буй. Энэ хүрээнд 1700 м.кв талбайтай "Бизнес инкубатор"-ын барилгыг ашиглалтад оруулж судалгаа, хөгжүүлэлт, бойжуулалтын ажлаа эхлүүлээд байна.

### Нийт санхүүжилт: **5 ТЭРБУМ ТӨГРӨГ**

Эрдэнэт ШУТП бизнес эрхлэгчдийг дэмжиж шинэ тоног төхөөрөмж худалдан авах зориулалт бүхий 800 сая төгрөгийг олгов.



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ

Монгол Улс БНХАУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 51.8 сая, Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн "Эрчим хүч 2" төслийн хүрээнд 19 тэрбум төгрөгийн өргөтгөл шинэтгэл хийжээ.

### Нийт санхүүжилт: **56 САЯ ДОЛЛАР**

#### Хүчин чадал: **ХОЁР ДАХИН НЭМЭГДЭВ**

Өгөөж: Цахилгааны үнэ 181 төгрөгөөс **104 ТӨГРӨГ БОЛЖ БУУРСАН**

Ашиг: Цахилгаан дамжуулах байгууламжийн өргөтгөл шинэтгэл хийв. Жилд 20 тэрбум төгрөг



## ЭРДЭНЭТ ХОТЫН ТОХИЖИЛТ

Эрдэнэт хотын Хүрэн булаг, Оюут, Уурхайчин, Зэст багийн тохижилтыг 1.6 тэрбум төгрөгөөр хийж, Баянцагаан, Говил, Эрдэнэ багуудад "Багийн төвийн цогцолбор"-ыг шинээр барилаа. Мөн Залуучуудын ордон, Жаргалант сумын ахмад, залуучуудын ордон ашиглалтад орлоо. Гэрч, хохирогчийг хамгаалах "Хүүхдийн хөгжил, хамгааллын төв"-ийн барилгыг барьж байна.



**Хатуу хүчилттэй зам: 3.9 КМ**

**Тохижуулсан баг:** Хүрэн булаг, Оюут, Уурхайчин, Зэст

**Автовокзалын барилга:** 2 тэрбум төгрөг

**Шинэ барилга байгууламж, цогцолбор:** 7



## ЗАМ ДАГАЖ ХӨГЖИЛ

Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт хатуу хүчилттэй авто замын төслийн санхүүжилтийг ЕСБХБанк санхүүжүүлэх боломжтой хэмээн албан ёсоор мэдэгдсэн юм. Монгол Улсын Засгийн газар ЕСБХБ хооронд байгуулагдах 300 сая долларын гэрээнд тус замын санхүүжилт мөн тусаад буй. Энэхүү төсөл нь бус нутгийн хэмжээнд эдийн засгийн өсөлтийг бий болгох, шинэ ажлын байр бүтээх, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, тээвэр ложистик, худалдааны салбарт эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Мөн Эрдэнэт-Хангал-Хялганат чиглэлийн 64 км авто замын ажил амжилттай үргэлжилж байна. Ирэх жил төлөвлөгөөний дагуу ашиглалтад орно.

**Төлөвлөж буй авто замын нийт урт: 92.28 КМ**  
**Төсөвт өртөг: 150.34 ТЭРБУМ ТӨГРӨГ**

**Төслийн эдийн засгийн болон бусад үр ашиг:**

Замд холбогдох аймгууд: Төв, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл

**Төслийн өгөөж: ЖИЛД 87 ТЭРБУМ**

**52 САЯ ТӨГРӨГ**

Мөн Эрдэнэт-Хангал-Хялганат чиглэлийн 64 км авто замын ажил амжилттай үргэлжилж байна. Ирэх жил төлөвлөгөөний дагуу ашиглалтад орно.



## ЭРҮҮЛ ЭРДЭНЭТ ХОТ

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ОНЦГОЙ АНХААРЧ АЖИЛЛАСНЫ ҮР ДҮНД ШИНЭ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ 4-ӨӨР НЭМЭГДЛЭЭ. МӨН ГҮЙЦЭТГЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛСНААР ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТNUУД ЦАЛИНГАА НЭМЭГДҮҮЛЖ, НИЙГМИЙН АСУУДЛАА ШИЙДВЭРЛЭЖ, АНХАН ШАТНЫ ЭМНЭЛГИЙН САНХҮҮЖИЛТ ӨСӨЖ 307,6 ТЭРБУМ ТӨГРӨГ БОЛОВ.

**Тоног төхөрөөмж:** **3.9 ТЭРБУМ ТӨГРӨГ**  
**Эрүүл мэндийн төв:** **3.95 ТЭРБУМ ТӨГРӨГ**



## БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ ХОТ

Эрдэнэт хотод Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй төслийн хүрээнд шаардлагатай машин механизмыг хүлээн аваад байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалт үргэлжилж байгаа бөгөөд ашиглалтад орсноор хог хаягдал боловсруулах үйлдвэр, хог дарж устгах талбайн хөгжүүлэлт, бүрэн цогц тоног төхөөрөмж шийдвэрлэгдэнэ.



**Нийт санхүүжилт:** **9 САЯ ЕВРО**

**Төслийн үр ашиг:** Хогийн цэгт төвлөрөөд буй 6 сая шоо метр хог хаягдал 30-50%-иар буурна.

**Бүтээн байгуулалт:** Хог хаягдал боловсруулах үйлдвэр

**Хөгжүүлэлт:** Хог дарж устгах талбайг хөгжүүлнэ

**Тоног төхөөрөмж:** 6 төрлийн 12 машин



# Тэр өнгөрсөн дөрвөн жилд иргэдэд хэрэгтэй ямар шийдвэрүүдэд нөлөөлөв?

УИХ-ын гишүүн Д.Батлут хэвлэлийнхнээс зай барьдаг гишүүдийн нэг. Гэхдээ тэр байгаа байхгүй нь мэдэгдэхгүй, хийж гавьсан зүйлгүй гишүүдээс тэс өөр нэгэн. Нийгмийн, эрүүл мэндийн, орон нутгийн асуудлаар өрнөсөн хуулийн төслүүдийн ажлын хэсэгт багтаж, санаа оноогоо тод тусгаж чаддаг чамбай улстөрч. Өнгөрсөн дөрвөн жилд түүний идэвхтэй оролцоотой ажилласан хууль, шийдвэр, шийдэл, байр сууриудаас тоймлон хүргзэе.

## Нийгмийн даатгалын хувь буурч, өрхийн эмч нарын цалин өсөв

Аймгийн Засаг даргын алба хашиж, асуудлын гүнд орж ажиллаж яваад УИХ-д орж ирснийг нь батлах цөөнгүй хууль бий. Наад захын жишээ гэхэд хэсэг гишүүдийн хамт өргөн барьсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл байна. Хууль батлагдсанаар ажил олгогч, ажилчны төлж байгаа тэтгэврийн даатгалын шимтгэл 1 хувиар буурсан юм. Сайн дураар тэтгэврийн даатгалд хамрагсдад ч энэ хөнгөлөлт үйлчилнэ. Уг хөнгөлөлтийг 49700 ажил олгогч, 168000 нийгмийн даатгал төлөгч өдэлж буй.

Тэрээр эрүүл мэндийн хууль, тогтоомжууд амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг судлах үүрэг чиглэл бүхий

ажлын хэсгийг ахалсан юм. 2020 оны зун дөнгөж бүрдсэн УИХ ийм ажлын хэсэг гаргасан нь цаанаа учиртай. Тухайн үед эрүүл мэндийн салбарынхан ажил хаялт зарлаж байв. Д.Батлут гишүүний ахалсан ажлын хэсэг олон ч газрын үйл ажиллагаатай танилцаж, эрүүл мэндийн салбарт болж бүтэхгүй байгаа зүйлсэд дүгнэлт хийж, зөв гольдрилд нь оруулах анхан шатны чиглэлүүдийг гаргаж байлаа. Тэр үеэс улбаатайгаар шийдлээ олсон асуудлын нэг бол анхан шатны эмнэлгүүдийн санхүүжилт сайжирсан явдал. Төсөвт тодорхой хэмжээний эх үүсвэр нэмж тусгаснаар өрхийн эмч нарын цалин өссөн юм. Эрдэнэтэд гэхэд л өрхийн эмч 2.2 сая, сувилагч

1.8 сая, асрагч үйлчлэгч 1.2 сая төгрөгийн цалинтай болсон билээ. УИХ-ын гишүүн Д.Батлут “Өрхийн эмнэлгүүд хүмүүст хүрч ажилласан хэмжээ, чанараараа санхүүжилт авдаг болсон. Үйлчилгээгээ сайжруул гэж үүрэгдэхээс илүү санхүүгийн ийм шийдэл хэрэглэчихээр өрхийн эмнэлгийн иргэдэд үзүүлэх үйлчилгээ сайжраад ирж байгаа юм. Эцсийн дүнд нь жирийн иргэл л хожно. Гэхдээ мэдээж асуудал бий. Цөөн хүн амтай сумын эмнэлгийн санхүүжилтийн асуудал жаахан учир дутагдалтай. Тэнд коэффициентийн зохицуулалт хийгээд явж байна” гэж ярилаа. Буйдхан сумын өрхийн эмнэлгийн санхүүжилтийг сайжруулахад анхаарч, өрхийн эмч нарын цалинг нэмэх санаа, шийдэл нийгмийн бүх л асуудалд хутгалдаж, иргэдийн амьдралыг доторлож, гадарладаг Д.Батлут шиг улстөрчдөөс л гарна.



## Хуурамч эм, эмийн үнийн өсөлттэй тэмцэнэ

УИХ-ЫН ГИШҮҮН Ж.Чинбурэн энэ хавар хуурамч эм, эмийн үнийн өсөлттэй тэмцэхээ зарлаад буй. Д.Батлут гишүүний хувьд эрүүл мэндийн хууль, тогтоомжууд амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг судлах үүрэг чиглэл бүхий ажлын хэсгийг ахласан 2020 оноос л энэ сэдвээр хүчтэй дуугарч эхэлсэн юм. Тэрээр нэгэнтэй “Монополь компаниуд нийлүүлэлтийг удирдаж эмийн үнийн хөөрөгдөл бий болгодог. Гэтэл “Монос” компанид эм, эмнэлгийн хэрэгслийн жижиглэнгийн худалдаа эрхлэх зөвшөөрлийг төрөөс олгожээ. Нийлүүлэлтийг бүрэн хянах боломжтой том компани жижиглэнгийн зах зээлд орвол үнийг удирдах давуу эрх нь улам баталгаажна. Орон нутагт ажиллаж байгаа эмийн сангүүдад өдөр ирэх тусам эмийн үнэ өсөж байгаа нь үнэн. Манай улсад зарагдаж

буй эмүүд чанартай үгүйг мэргэжлийн байгууллагууд нь иргэдээс авсан санал асуулгаар УИХ-ын түр хороонд танилцууллаа. Уг нь чанартай эсэхийг нь мэргэжлийн лабораторийн дүгнэлт, туршилт, судалгаагаар гаргах ёстой. Үүнийг хийж иргэдэд мэдээлж, сэргэжлүүлэх ёстой байгууллагууд нь иргэдээсээ асууж байгаа нь ичгүүртэй хэрэг. Эмийн үнэ яагаад өссөнийг зах зээлийн судалгаа, мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтээр тогтоох байтал эм зардаг компаниудаас үнэ яагаад өсгөсөн талаар нь асууж УИХ-д мөн танилцууллаа. Төр ийм чадамжгүй байвал олон нийт юунд найдах вэ” хэмээн шүүмжилж байв.

Дашрамд тодотгоход манай улсын эмийн зах зээлд борлуулагдаж байгаа эмийн 11 хувь нь стандарт бус,

4.29 хувь нь бүртгэлгүй бол эм эмнэлгийн тоног төхөөрөмжийн бизнес “ганзагын наймаа”-ны буюу мафижсан хэлбэр рүү шилжээд буй. Байдал иймдээ тулсан ч УИХ хуурамч эм, эмийн үнэ, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мафижсан бизнесийн эсрэг тодорхой бөгөөд даацтай шийдвэр гаргаагүй яваа юм. Д.Батлут гишүүн “Улстөрч хүн нийгмийн ийм эмзэг асуудалд онцгой анхаарах ёстой. Миний хувьд хуурамч эм, эмийн үнийн өсөлт, эмнэлгийн тоног төхөөрөмж тойрсон хууль бус наймааны асуудлыг үргэлжлүүлэн хөндсөөр байх болно. Өөрийн зүгээс хийж чадах ямар л нөлөөлөл байна, тэр бүхнээ тултал зүтгэнэ” хэмээн хэвлэлд ярьж байж. Ингээд хархаар хэрийн улстөрч барьж авахаас татгалздаг, олон жил бугшсан эм, эмнэлгийн тоног төхөөрөмж тойрсон асуудлыг Д.Батлут шиг асуудлынхаа гүнд орж, шийдүүлэхийн төлөө зүтгэж чаддаг улстөрчид л шийднэ гэдэгт эргэлзэх зүйл алга.

## Орон нутгийн иргэд төсвөө өөрсдөө мэддэг болов

Д.Батлутын идэвхтэй оролцоотой ажилласан шийдвэрийн нэг бол 2020 оны арванхоёрдугаар сард батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийг нэгж, түүний удирдлагын тухай хууль юм. Энэ хууль батлагдсанаар орон нутаг бие даах бодит нөхцөл бурдаж байв. Энгийн нэг зүйрлэл хэлье. Босоо удирдлага хүчтэй байсан өмнөх жилүүдэд сумын сургуулийн цонх хагарлаа гэхэд сумын дарга аймгийн удирдлага руу, аймаг нь Сангийн яам руу, Сангийн яам Засгийн

газар руу хандаж байж ганц цонхны мөнгө шийдэгдэг байв. Харин өнөөдөр орон нутгийн удирдлага болоод иргэд сургуулийн хагарсан цонхноос эхлээд концессийн гэрээ хийх, үнэт цаас гаргах асуудлыг хүртэл өөрсдөө бие даан шийдэх хуулийн орчин бүрдээд байна. Д.Батлут гишүүн уг хуулийн талаар “Эрх мэдлийн төвлөрлийн зарим асуудлыг доод төвшинд шилжүүлж чадсан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийг нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэлийн гол онцлог. Орон нутгийн

иргэдэд нутгийнхаа асуудлыг шийдэхэд оролцох эрхийг олголоо. Бүр тодруулж хэлбэл орон нутаг төсвөө өөрөө батлах, ярилцах, хэлэлцэх бодит орчин бүрдсэн. Тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн амьдралд үгүйлэгдэж байгаа асуудлыг иргэд өөрсдөө санаачлах, хэлэлцэж шийдвэр гаргуулахаар хандах эрх зүйн орчинг бүрдүүлж өглөө. Энэ бол үнэхээр дэвшилттэй, шинэлэг зохицуулалт. Үүний өгөөжийг бодит амьдралд хүртэхийн тулд иргэд өөрсдөө идэвхтэй оролцоотой байх “хэрэгтэй” хэмээн байр сууриа илэрхийлж байж.

## Зөрчлийн хуулийн иргэдэд дарамт болсон заалтыг өөрчлөв

Зөрчлийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт дээр гардаж ажилласан гишүүдийн нэг бол Д.Батлут. Өмнө нь нэг зөрчил дээр иргэдэд хоёр давхар шийтгэл оноодог байсан юм. Тодруулж хэлбэл зам тээврийн зөрчил гаргасан иргэд мөнгөөр торгуулахаас гадна оноо болон эрхээ хасуулж шийтгэл хүлээдэг байв. Зөрчлийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр давхар шийтгэлийг арилгаж чадсан юм. УИХ-ын гишүүн Д.Батлут энэ тухай “Ямар нэг байдлаар зөрчлийг үнэлж үзэхэд иргэн засчих боломжтой зөрчлүүд дээр шууд торгох шийтгэл

оногдуулж байсан. Тиймээс олны зүгээс бухимдал, шүүмжлэл ихээр ирэх болсон. Бухимдахаас аргагүй зохицуулалт байсан л даа. Иймээс Зөрчлийн хуульд иргэдэд хөнгөлөлт өдлүүлэх боломжийг бүрдүүлсэн заалтуудыг оруулж өгсөн. Тухайлбал, шууд торгох биш эхлээд сануулдаг байх зохицуулалтыг тусгалаа. Тухайн зөрчил ямар цаг хугацаанд үйлдэгдсэн, нийгэмд хэр хор хохирол учруулж байгаагаас шалтгаалаад эхлээд сануулж, дараа нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, дараа нь торгууль оногдуулдаг байдал руу

орсон. Иргэдтэй уулзаж явахад давхар шийтгэлийн асуудал, мөн торгохоосоо өмнө сануулж болдоггүй юм уу гэдэг зүйл ярьдаг байсан юм. Олон иргэн ийм саналтай байсан учраас бид энэ хуулийн санкцуудыг хуулийн амин сүнс болгож орууллаа. Зөрчлийн хуулиар шийтгүүлж буй иргэдийн 90 орчим хувь нь зам тээврийн зөрчлүүд гаргасан байдал. Давхар шийтгэл маш их оноодог байсныг болиулсан гэсэн үг” хэмээн онцолж байна.

## Бичил бизнес эрхлэгчдийг дэмжинэ

Д.Батлут гишүүний онцгойлж анхаардаг нэг өнцөг бол бичил бизнес эрхлэгчдийг бодитой дэмжих орчныг бий болгох. Тэрээр УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад тун удахгүй багтах Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж парламентаар хэлэлцүүлэхээр ажиллаад эхэлчихэж. Одоо үйлчилж буй Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд жилийн 300 саяас 1 тэрбум хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10-50 хүнийг ажлын байраар хангадаг бизнесийг “жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”, харин 300 сая хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй 10 хүртэлх хүнийг ажлын байраар хангадаг бол “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” хэмээн тодорхойлдог. Гэтэл бодит байдал дээр ЖДҮ эрхлэгчдийн бараг 50 орчим хувь нь 50 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлоготой байдаг аж. Үүн дээр хувиараа бизнес эрхлэгч иргэдийг нэмбэл илүү өндөр тоо гарна. Ингээд харахаар төрөөс олгож буй хөнгөлөлттэй зээл тусlamж, татварын хөнгөлөлт зэрэг ЖДҮ эрхлэгчдийн тэн хагас нь хамрагдаж чадахгүй байгаа юм.

Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг батлуулж чадвал төрөөс олгож буй хөнгөлөлттэй зээл тусlamж, татварын хөнгөлөлтийг ЖДҮ эрхлэгчид маань хүртэх боломж бий

болов юм билээ. УИХ-ын гишүүн саяхан хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Одоо үйлчилж буй хуулиар бичил бизнес эрхлэгчдэд 300 саяын эргэлтийн хөрөнгөтэй гэсэн босго тавьчихсан. Ийм өндөр босгыг бичил бизнес эрхлэгчид давж чадахгүй. Бичил бизнес эрхлэгчдийн жилийн эргэлт 20, 30 саяар л хэмжигддэг. Энэ мөнгөнд нь тохирсон зээлийн нөхцөл тавьж өгөх хөрөгтэй. Тэгж байж өрхийн үйлдвэрлэл хөгжинө” хэмээн онцолжээ.

Түүний хувьд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих энэ шийдэл зүгээр л нэг цээжний

пангаар ярьж буй зүйл биш. Орхон аймгийн Засаг дарга байхдаа бичил бизнес эрхлэгчдэд тав хүртэл сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй зээл олголтыг эхлүүлж, өдгөө уг зээлийнх нь эргэн төлөлт 90 хувь давчихсан яваа. Гэтэл жижиг, дунд сангийн зээлийн эргэн төлөлт 20, 30 хувиар л хэмжигдэж буй. Д.Батлутын санаачилж боловсруулсан Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн төсөл батлагдвал зээлд хамрагдаж чаддаггүй бичил бизнес эрхлэгчдийн бизнес тэлж, өрхийн үйлдвэрлэл жинхэнэ утгаараа тэлэх нь тодорхой ажээ.





## ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ПАРК

*Инкубаторт бойжуулсан инженерийн санаа  
эдийн засгийн үр шимээ өгч эхэллээ*

Даяаршиж буй дэлхий  
дертэнцэд компани, аж  
ахуйн нэгжүүдийн өрсөлдөх  
чадварыг нэмэгдүүлэхийн  
тулд шаардлагатай  
мэдлэг, мэдээлэл хийгээд  
материаллаг боломж нэг  
дор байх нь ямар чухлыг  
өндөр хөгжилтэй улс  
орнуудын замналаас харж  
болно. Өөрөөр хэлбэл, хүн  
төрөлхтөн шинжлэх ухаанч  
мэдлэг мэдээллийг амьдрал  
дээр туршин, үр өгөөжийг  
нь судлах туршилтын дунд  
суурилан тухайн бүтээл, шинэ  
санааг улам сайжруулан  
баяжуулах замаар ажиллах

зарчмыг баримтлах болжээ.  
Манай улсын хувьд анхдагч  
хэмээгдэх Эрдэнэт Шинжлэх  
ухаан технологийн парк  
УИХ-ЫН ГИШҮҮН Д.Батлут  
Орхон аймгийн Засаг  
даргаар ажиллаж байхдаа  
санаачилснаар 2017 онд  
сууриа тавьсан агаад өдгөө  
тус паркад 11 төсөл бойжин  
эхнээсээ өдийн засгийн үр  
өгөөжөө өгч эхэлжээ. Тус  
паркийн Бизнес инкубатор  
2020-2022 онд орон нутгийн  
хөрөнгө оруулалтаар  
байгуулагдсан бөгөөд нэг га  
газартай. Гарааны компани  
инновацийн бүтээгдэхүүний

үйлдвэрлэлийг зориулалтын  
ажлын байраар хангах  
зорилготой агаад эхний  
барилга болох 1750 мкв ажлын  
байранд үйл ажиллагаагаа  
явуулж буй бол хоёр дахь  
барилгыг энэ жил улсын  
төсвийн хөрөнгө оруулалтаар  
барих гэж байна. Өөрөөр  
хэлбэл, улсын хэмжээнд  
цор ганц инновацийн  
бүтээгдэхүүн бойжуулах  
зорилготой инкубаторын үйл  
ажиллагаа бүсчилсэн хөгжилд  
ямар их хувь нэмэр оруулах  
боломжтойг бодит жишээн  
дээр түшиглэн сурвалжлахыг  
зорилоо.

*О.Батсуурь:*

## БИДНИЙ ТӨСЛИЙН ГОЛ ЗОРИЛГО АЛСАРСААР БҮЙ ТҮҮХ, АХҮЙ УЛАМЖЛАЛАА АВЧ ҮЛДЭХ ЯВДАЛ

*"Агар төгөл" ХХК-ийн захирал*

Эрдэнэт үйлдвэрийн засвар механизийн заводод тоо, удирдлагатай суурь машины оператор буюу техникийн загварчнаар ажилладаг О.Батсуурь 2020 онд найзын хамт үйлдвэрээ байгуулжээ. Түрээсийн жижигхэн өрөөнд эхлэлээ тавьж байсан тэд өдгөө Монгол Улсын аялал жуулчлалын салбарт "тэсрэлт" болохуйц пазль буюу угсардаг модон тоглоомыг зах зээлд нийлүүлэхээр судалж, шинэчлэн сайжруулсаар байна. Гарааны бизнесийн өмнө тулгардаг асуудлын нэг болох түрээсийн байрны гачлангаас гарсан тухайгаа тэрбээр "2022 онд УИХ-ын гишүүн Д.Батлутад төслөө танилцуулж, орхигдсон өрхийн эмнэлгийн нэг давхар барилгыг 5 жилийн хугацаанд ашиглахаар гэрээ байгуулсан нь бидэнд том дэм болсон" хэмээн тайлбарласан.

UV принтер бол хүссэн бүх хувтгай гадаргуун дээр хэвлэдэг төхөөрөмж. 3D технологи ашиглан бэлэг дурсгалын зүйл хийж буй тус үйлдвэрийнхэн хүнсний зориулалттай модон фанер дээр бүтээгдэхүүнээ хэвлэдэг. Одоогоор захиалгаас олсон орлогоосоо цоо шинэ төслөө санхүүжүүлж байгаа аж.

Шинэхэн төслийн тухайд залуус 21 аймгийн пазль хийж буй агаад аймгуудын салах

**“ Түрээсийн жижигс өрөөнөөс бизнесээ зэхэлсэн залуус аялал жуулчлалын салбарт брэнд болохуйц угсардаг модон тоглоомыг зах зээлд нийлүүлэхэд бэлэн болжээ.**

хэлбэр нь сумдаар задарна. Өөрөөр хэлбэл, сум, аймаг, комик хэлбэрээр цуглувубал, Монгол Улсын газрын зураг

болно. Цогцоороо пазлиас гадна түлхүүрийн оосор дагалдах агаад ухаалаг утсан дахь аплейкшнд уншуулснаар тухайн бүс нутгийн үүх түүх, байгалийн гайхамшигийн мэдээлэлтэй танилцан, аяллын маршрутаа сонгох боломжтой. Залуусын тухайд танин мэдэхүй, эрүүл ахуйг чухалчилснаас гадна улам бүр алсарсаар буй үүх түүх, уламжлаа хүүхдүүдэд ойртуулахыг хүсэж байгаа юм билээ. ШУТП-ийн санхүүжилтээр UV принтер гэхчлэн тоног төхөөрөмж, лазер зүсэгчийнхээ асуудлыг шийдэж, үйл ажиллагаагаа сайжруулж буй тэд хайрцаг сав, баглаа боодлоо ч үндэсний үйлдвэрлэгчдийнхээ хэмжээнд шийдэх арга гарцаа аль хэдийнэ олжээ. Төсөл бүрэн хэрэгжиж дууссанаар монгол ахуйгаас алсарч буй орчин цагийн хүүхдүүд танин мэдэхүйн асар их мэдээлэлтэй болохоос гадна Монголыг зорих жуулчдын гарын авлага, хөтөч болох бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэх цаг дөтөлсөөр байна.



М.Цэнгүүн:

## ХАЯГДЛААС ГАРГАСАН УТААГҮЙ ТҮЛШНИЙХЭЭ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАМГИЙН АНХНЫ УТААГҮЙ АЙМАГ БОЛОХЫГ ХУСДЭГ

“Мянган Бэрс” ХХК-ийн үйлдвэрлэл хариуцсан захирал

Суурин амьдралын сөрөг тал нь утаа. “Мянган Бэрс” ХХК-ийнхан утааны эсрэг аянд нэгджээ. ШУТП-ийн зүгээс зарласан “Хөөрхөн Эрдэнэт” уралдаанд бүтээлээрээ тэргүүлж, дэмжлэг авснаар тэд ажлынхаа анхны шанг татжээ. Төслийн хэмжээнд яригдаж байсан утаагүй түлшний үйлдвэрлэл өнгөрсөн намар Ингэт толгой сумын хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж авч, хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна. Тус компани 2022 онд байгуулагдаж 2023 оноос эхний бүтээгдэхүүнээ худалдаанд гаргаж эхэлсэн ч бүтээгдэхүүн нь хурдан хугацаанд дуусаад байсан тул үйлдвэрлэлээ өргөжүүлэх шаардлага тулгарсан аж. Энэ үед Эрдэнэт ШУТП-аас гарцааны бизнесийг дэмжих чиглэлээр төслийн уралдаан зарлаж, төслөө бичиж оролцсоноор хүүгүй, барьцаагүй, гурван жилийн дараагаас эргэн төлөх



нөхцөлтэйгөөр 40 сая төгрөгийн санхүүжилт авч чаджээ. Тус үйлдвэр хоногт 4 тонн түлш үйлдвэрлэх хүчин чадалтай ч одоогоор 2 тонныг үйлдвэрлэж байна. Үйлдвэрлэлийн технологийн тухайд хаягдал ашигладаг. 12-13 кг хаягдал цаас, 500 гр үртсээр 14 кг түлш үйлдвэрлэж, зах зээлд нэг шуудайг нь 6500 төгрөгөөр нийлүүлдэг. Түлшний шатах хугацаа, дулаан ялгаруулах чадвар нь нүүрстэй ижил бөгөөд үнийн хувьд нэг шуудай нүүрснээс дунджаар 3000 төгрөгөөр хямд юм. Хамгийн гол нь барьцалдуулагч ашигладагтүй учир ямар

нэг химийн хорт утааны айдасгүй эко бүтээгдэхүүн гэж ойлгож болно. Мөн тэд хаягдал цаасыг ургамлын болон малын гаралтай тостой холин эко гал асаагч гаргажээ. Үүнийгээ 500 гр-аар савлан 1000 төгрөгөөр борлуулдаг юм байна. Залуусын судалгаагаар хогийн цэгт хаяж буй нэг машин хогийн 50 хувь нь цаас, цаасан бүтээгдэхүүн байдаг учраас түүхий эдийн дутагдалд орохгүй агаад зунжингаа ажиллаад нөөц бүрдүүлэх, цаашид үйлдвэрээ улам бүр өргөжүүлэн хог хаягдлаас ангижрангаа эко түлшээр иргэдээ хангах ирмүүн зорилготой ажиллаж байна.



Г.Энхбаяр:

## 50 ТЭРБУМ ТӨГРӨГ ЭРГЭЛДДЭГ БУДГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 50 ХУВИЙГ ХАНГАХ БОЛОМЖТОЙ

ШУТП-ийн захирал, доктор

Шинжлэх ухаан технологийн паркад бойжиж, эдийн засгийн үр өгөөжөө өгч өхэлсэн дөрвөн төслийн нэг нь будгийн үйлдвэр. Өнөөдрийн байдлаар 20 орчим тонн будаг үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлжээ. 2017 оноос хойш судалгаа хийгдэж байгаад 2019 онд ашиглалтад орсон үйлдвэрийн бүтээгдэхүүний стандарт нь евро стандартын усан суурьтай будаг. Ахуу 15 нэр төрлийн бүтээгдэхүүнээр хязгаарлагдаж байсан бол өдгөө 46 нэр төрөл болж өргөжжээ.

Монголын будаг болон түүний дагалдах бүтээгдэхүүний зах зээлд 50 орчим тэрбум төгрөг эргэлддэг бөгөөд үйлдвэрийг төслийн хэмжээнд нь бүрэн хүчин чадлаар ажилуулбал зах зээлийн 50 хувийг хангах тооцоолол байна. Бүтээгдэхүүний тухайд дотоодын технологиор гаргаж авсан агаад монгол инженерийн ур чадамжийг европ стандарт хүлээн зөвшөөрсөн гэсэн үг. 30 хувийн ус, 40 хувийн байгалийн чулуунаас бүрддэг монгол будаг ямар ч үнэргүй агаад цагийн дотор хатдаг онцлогтой. Одоогоор Эрдэнэт,

Улаанбаатарт борлуулагдаж буй бүтээгдэхүүнээ ирэх тавдугаар сараас хойд бүс буюу Хөвсгөл, Булган цаашлаад 21 аймагт борлуулахаар төлөвлөжээ. Мөн замын хэвтээ тэнхлэгийн будаг үйлдвэрлэж өхэлсэн нь эрэлт хэрэгцээ ихтэй байгаа гэнэ.

Шинжлэх ухаан технологийн паркад бойжсон бас нэг төсөл бол мөөгний хиймэл хөрсний үйлдвэрлэл. Дулааны улиралд тариалалтаа хийдэг агаад зургадугаар сараас ажиллаж өхэлдэг Эрдэнэт

хотын худалдааны гудамжнаас эрт очиж худалдан авах боломжтой. Эрдэнэтийн худалдааны гудамжнаас өглөө эрт халуун талх, хүлэмжээс хүргэгдсэн мөөг, улаан лооль, өргөст хэмх авдаг зурсшил өдгөө хэвшил болон тогтжээ.

Монгол инженерүүдийн ур ухаанаар бүтсэн гагнуурын электродын хамгийн том худалдан авагч нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр. Одоогоор нэг тэрбум орчим төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авсан агаад ШУТП ашгийнхаяа тодорхой хувийг дараагийн төслөө бойжуулахад зарцуулдаг юм байна. Өөрөөр хэлбэл бичил бизнесийг дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй зээл олгодог сайн жишиг хэрэгжиж байна. Тодруулбал өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид нэн шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж авч өгөөд бизнесээ тогтвортой үргэлжлүүлбэл хоёр жилийн дараа хувийн өмчлөлд шилжүүлдэг гэнэ.



Орхон, Хөвсгөл, Булганыхныг  
хангалуун амьдруулах төгс  
жор буюу

# АЖ ҮЙЛДВЭР, ТЕХНОЛОГИЙН ПАРК



**А**ль өрээд оноос Монгол Улсын төсвийн орлогын хамаг ачааг нуруундаа үүрч явваа “Эрдэнэт” үйлдвэрийг түшиглэсэн Аж үйлдвэр, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил эхэлчихэж. Дан ганц Эрдэнэтийнхэнд ч биш Монгол Улсын эдийн засагт маш таатай мэдээ. Энэ паркад Зэсийн баяжмал хайлуулж боловсруулах үйлдвэр, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах катодын зэсийн үйлдвэр, Молбидений баяжмал боловсруулах үйлдвэр ажиллаж эхэлнэ. Зэсээ зөвхөн баяжмал хэлбэрээр гаргадаг Азийн Монгол боловсруулсан цэвэр зэсээ маш өндөр ханшаар дэлхийн зах зээл дээр борлуулах үүд нээгдэнэ гэсэн үг. Бүр цаашилбал Оюу толгой, Цагаан суварга гэх мэт ордын зэсийг энд хайлуулж боловсруулаад эхэлбэл Монгол Улс дэлхийн зэсийн зах зээл дэх тод тоглогчдын нэг болно.

Ирэх жилүүдэд хэрэглээ нь улам өсч, “моод”-нд орох цахилгаан машины гол түүхий эдийг өндөр төвшинд боловсруулж гаргах хэрээр олох мөнгө маань огцом өсч, эдийн засаг мэдрэгдэхүйц тэлэх нь хоёр дээр хоёрыг нэмэхэд дөрөв гардаг шиг тов тодорхой зүйл. Уул уурхайд хөрөнгө оруулж, хайгуул хийдэг “акул”-үүд ногоон эрчим хүчний “мотор” болсон зэсийн ханш жил ирэх бүр чангарахыг анзаарч, энд тэндгүй хайгуул өрнүүлж буй. Манай Оюу толгойг нээсэн Фрийдландын компани гэхэд л Конгод зэсийн томоохон орд илрүүлж, дэлхийн зах зээл



Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Монгол улсын бахархал юм

дэх том тоглогчдын нэг болно гэсэн амбиц тээн бужигнуулж явна. Энэ төслийнхөө ачаар Африкийн жижигхэн Конгог дэлхий мэдэх болсон. Тун удахгүй “Конго улсын эдийн засаг ингэж тэгж өслөө” гэсэн мэдээ BBC, CNN-ээр цуврах биз. Мега төсөл хэрэгжихийн гол давуу тал ерөөсөө л энэ.

Аж үйлдвэр, технологийн парк хэзээ ашиглалтад орох талаар УИХ-ЫН ГИШҮҮН Д.Баттуаас тодруулахад “Паркад байгуулагдах гурван үйлдвэр ирэх оноос эхлээд ээлж дараатай ашиглалтад орж эхэлнэ. Зэс хайлуулах үйлдвэрийн тухайд өмнө нь Бор-Өндөр, Өмнөговь гээд олон газар барина гэж ярьсан ч бүтэлтэй юм болоогүй. Тэр бүхний эцэст Эрдэнэт

үйлдвэрийг түшиглэсэн Аж үйлдвэр, технологийн парк баригдах болсон нь том олзуурхал шүү” гэсэн хариу өгч байна.

Аж үйлдвэр, технологийн паркийн бүтээн байгуулалтад зарцуулагдах нийт хөрөнгө оруулалт нэг тэрбум ам.доллараар хэмжигдэж буй. Эдийн засгийн үр өгөөж нь хэр вэ гэсэн асуулт тавиад харья. Зөвхөн зэс хайлуулах үйлдвэр гэхэд л жилд 50 сая орчим ам.доллар төвлөрүүлэх нь. 800 гаруй

**“Хөвсгөл, Булган, Орхон аймгийн жижиг дунд үйлдвэрлэгчдэд энэ мега төслийн өгөөжөөс шууд хүртэх боломж нээгджээ.**

дажгүй цалинтай ажлын байр бий болохоос гадна шууд бус дагалдах байдлаар 9000 ажлын байр гарах нөхцөл бүрдэх юм байна. Мега төслийн нэг онцлог нь дагалдсан олон төсөл бий

болж, жижиг, дунд үйлдвэрлэл жинхэнэ утгаараа цэцэглэдэг. Үүний том жишээ нь Оюу толгой. Цагтаа гээгдсэн суурингуудын нэг байсан Өмнөговийн

Ханбогдод өдгөө газар олдохоо байсан, худалдаж авьяа гэвэл маш үнэтэй. Сумын олон иргэн Оюу толгойд ханганд нийлүүлэлт хийдэг дориун бизнестэй, хүүхдүүд нь Кембрижийн сургалттай сургуульд суралцдаг, Оюу толгой тойрсон сумын иргэд ажилгүй орлогогүйн зовлонгоос хэдийнэ салсан гэж ирээд яривал мега төслийн өгөөж их.

Эрдэнэтэд баригдаад эхэлсэн Аж үйлдвэр, технологийн парк ч ялгаагүй ийм эерэг нөлөө үзүүлнэ. Дахиад онцлоход дан ганц Эрдэнэтэд ч биш улс даяар ашгаа өгнө. Эрдэнэтийнхэн шиг шууд, том өгөөж хүртэх газар гэвэл Орхон аймагтай залгаа Булганыхан. Хойд бус гэдэг утгаараа Хөвсгөлийнхөн ч энэ төслийн өгөөжийг шууд хүртэх хэсэгт хамаарна.

Төгсгөлд нь онцлох нэг том олзуурхал байна. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэж барих Аж үйлдвэр, технологийн паркийг дагаж хөгжих бүтэц аль хэдийнэ бэлэн болчихож. Бүр энгийнээр хэлбэл Хөвсгөл, Булган, Орхон аймгийн жижиг дунд үйлдвэрлэгчдэд энэ мега төслийн өгөөжөөс шууд хүртэх боломж нээгджээ. Эрдэнэтэд

Шинжлэх ухаан, технологийн парк гэж бий. Гарааны төслүүдэд хүүгүй, барьцаагүй зээл олгож зах зээл дээр хөлөө олтол нь бойжуулдаг газар. Олон ч төслийг бойжуулснаас онцгой амжилттай яваа хоёр төсөл бий. Нэг нь евро стандартын будгийн үйлдвэр. Элдэв үнэр танаргүй, хүний биед сөрөг нөлөөгүй, ганцхан цагийн дараа


хатдаг гэсэн давуу талтай энэ будгийн үйлдвэр Монгол Улсын будгийн нийт хэрэглээний 50 хувийг хангах хүчин чадалтай. Өргөтгөл хийвэл нийт будгийн хэрэглээний 100 хувийг ч дангаараа нийлүүлж чадна гэж Шинжлэх ухаан, технологийн паркийг санаачлан байгуулсан Д.Батлут гишүүн онцолно лээ.

Тэрээр "Аж үйлдвэр, технологийн паркаа дагуулаад Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк байгуулчихвал түүхий эдийн татан авалт, анхан шатны гүн боловсруулалт сайжирна. Тэгж гэмээ нь гучин жил буруу явсан хөдөө аж ахуйн бодлого зөв чиг рүүгээ орно. Малчид маань алийн болгон буянт малынхаа түүхий эдийг үнэгүйдүүлж, хохирч суух вэ дээ. Өдгөө Монгол Улс хөдөө аж ахуйн экспортосоо 1.5 тэрбум ам.доллар олдог. Хэрэв анхан шатанд гүн боловсруулалт хийгээд экспортолбол 8-9 тэрбум ам.доллар олох

боловжтой. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв загвараар эдийн засгийн эргэлтэд оруулбал дэлхийд органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон байх боломж бидэнд бий. 80 сая малаа эдийн засгийн эргэлтэд зөв оруулчихвал иргэд маань баян, хангалийн амьдарна. Малчин айл болгон ягаад мини сүүний үйлдвэр ажиллуулж болохгүй гэж. Өрхийн үйлдвэрлэл, ер нь ямар ч үйлдвэрлэл дэд бүтэц нь бэлэн байвал хөгжихөд асуудалгүй. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн Аж үйлдвэр, технологийн парк байгуулагдсанаар үйлдвэр хөгжүүлэх хөрс болсон дэд бүтцээ шийдчих юм. Том паркийн бүтээн байгуулалт өрнөхөөс урьтаад Шинжлэх ухаан, технологийн парк байгуулсандаа баяртай байгаа. Манай паркад эрдэмтдийн зөвлөл ажиллаж, паркад бойжиж буй төслүүдэд зөвлөгөө чиглэл өгч ажилладаг учраас төслүүдийн үр дүн сайн байдаг. Зөвхөн Орхон гэж хязгаарлахгүйгээр Булган, Хөвсгөл гэх мэт хойд бүсийн аймгуудын малчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдийн төслүүдийг ч энэ паркдаа хөгжүүлж, бойжуулах боломж бий. Менежмэнт загварчлалыг нь гаргаад өгчихнө гэдэг иргэдэд маш том давуу тал. Манай паркад бойжсон төслүүд Аж үйлдвэр, технологийн паркад баригдах үйлдвэрүүдэд ханганд нийлүүлэлт хийх боломжтой. Өрхийн үйлдвэрлэл энэ мэтээр хөгжих боломж өндөр байна" хэмээн байр сууриа хуваалцсан юм. ■



# “Хөгжлийн алтан гурвал” буюу ШАР ХӨТӨЛИЙН ЗАМ



Европын Холбооноос Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан Траян Лауренцю Христеатай уулзах үеэр, 2022 он

**Ө**ссэн нутаг минь Төв аймгийн Жаргалант сумын Загдал баг. Сумаасаа хорь орчим км алслагдсан буйдхан газар л даа. Хуучин нийгмийн үед амьдрал буцалж байсан Загдал маань гээгдсэн суурингуудын нэг болоод удаж буй. Цөөхөн хүүхэдтэй бага сургууль, багийн захиргаанаас

өөр ажилладаг газар үгүй. Иргэд нь төмс, ногоохон тарьж амь зууна. Овоо бэлтэй нь малчид голдуу иргэд. Сүүлийн жилүүдэд манай нутгийнханд чихэнд чимэгтэй нэгэн сураг дуулдах болсон нь Жаргалант, Шар хөтөлөөр тавих зуу орчим км зам барина гэх мэдээ. Улаанбаатар-Шар хөтөл-

Эрдэнэт чиглэлийн энэ замын маршрут яг манай багийн нутгаар дайрна. Багаасаа зуугаадхан км давхиад Эрдэнэт гээд том зах зээл рүү очихно гэдэг яалт ч үгүй сайн мэдээ. Шар хөтөлийн замын хувьд өнгөрсөн сонгуулиар Орхон аймагт өрсөлдөж УИХ-ын гишүүн болсон Д.Батлутын

амласан амлалт байгаа юм. Мань эр УИХ-ЫН гишүүн болсныхоо дараа Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэлд Шар хөтөлийг замыг тусгуулж байв.

Энэ замын сургаар манай нутагт газрын үнэ өсч, газар авахыг хүссэн хүмүүс олшрох болсон. Товчхондоо эзгүүрсэн буйдхан суурин минь амь ороод эхэлчихсэн. Манай Загдал шиг замаасаа алслагдсан, хөгжлөөс гээгдэж үлдсэн олон жижиг сууринд амьдрал залгуулах Шар хөтөлийн замын ажил энэ хавартаа багтаад эхлэх нь тодорхой болчиж. Засгийн газар саяхан энэ замын эхлэл хөрөнгө болох 16 тэрбум төгрөгийг шийджээ. Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх Шар хөтөлийн зам ирэх онд ашиглалтад орно гэж УИХ-ЫН гишүүн Д.Батлут саяхан хэвлэлд өгсөн ярилцлагадаа онцолсон байна лээ.

Тэгэхээр Хөвсгөл, Булган, Эрдэнэтийнхэн ирэх жилээс Улаанбаатар руу зуу гаруй км-ын дөт замаар зорчдог болох нь. Булган аймгийн хойд, Сэлэнгэ аймгийн баруун хойд, Хөвсгөлийн олонх сумдын иргэдийн зорчих Шар хөтлийн замын урт нь 92.54 км. Нэг талдаа 100 км татуу зам туулна гэхээр 10, 20 литр бензиний мөнгө халаасанд үлдэнэ гэсэн үг. Авто замын иргэдэд ирэх шууд өгөөж нь энэ, шууд бус нөлөөг тооцвол овоо том тоо гарна. Түүний хүсч мөрөөдөж явдаг өөр нэг том бүтээн байгуулалт бол Улаанбаатар-Эрдэнэтийг холбосон 270 км хурдны авто зам юм билээ. Энэ

зам тавигдвал 50-60 км тутамд нь 150-200 мянган хүн амтай гурав, дөрвөн шинэ суурин байгуулагдана гэсэн тооцоо бий. Зам дагаж хөгжил гээд байдгийн том учир энэ л дээ.

“Зам дагаж хөгжил” гэдэг үгийн утга, ач тусыг мэдэрч, замын бүтээн байгуулалтад онцгой анхаардаг цөөхөн гишүүний нэг бол Шар хөтөлийн замын “автор” Д.Батлут. Эрдэнэт хотод гэхэд л замын цөөнгүй бүтээн байгуулалт өрнүүлсэн байх жишээний. Өнгөрсөн жилүүдэд хэвлүүлсэн ажлын тайланг нь сөхөхөд л “Эрдэнэт хот доторх авто замын засварт 50 тэрбум, Эрдэнэтийн зургадугаар бичил хорооллын уулзвараас Их-Залуу багийн уулзвар хүртэлх улсын чанартай авто замыг дөрвөн эгнээ болгож өргөтгөхөд 13 тэрбум...” гэсэн жагсаалт хөвөрч байна. Орхон аймгийн Уртын гол, Эрдэнэ багийг хатуу хучилттай авто замаар

холбосонд Эрдэнэтчүүд ам сайтай байдаг юм билээ. За тэгээд Дэнж, Эрдэнэ багийг холбосон авто замыг улсын төсвийн хөрөнгөөр барихад ч түүний оролцоо, нөлөө их байв. Хойд бүсийн Хөвсгөл, Булган аймгуудад шороон замаар яваар хүрдэг олон сум бий. Эдгээр аймгийн хувьд Шар хөтөлийн замаар Улаанбаатарыг зорих нь тодорхой болж байна. Хатуу хучилттай замаар сумдаа холбох ажлыг эрчтэй өрнүүлж чадвал хойд бүсийн аймгууд Д.Батлут гишүүний онцолсончлон “Монгол Улсын хөгжлийн алтан гурвал” болох цаг тийм ч холын мөрөөдөл биш. Ер нь УИХ-ЫН гишүүн бүр түүн шиг замын ашиг тус, өгөөжийг мэдэрч, замын бүтээн байгуулалтын төлөө гадаад, дотоодын санхүүжилтийг татах хэмжээний сэтгэлтэй ажиллавал эдийн засаг сэвхийгээд ирэх нь гарцаагүй. ■



Тус автозам нь Төв, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл аймгийг холбосон чухал төсөл юм.



БҮГДЭЭРЭЭ ХӨГЖЬЕ БУЮУ

# ХҮНИЙ ХӨГЖ

**Б**ид олон жил ядууралтай тэмцлээ. Үр дүн нь хүссэн хэмжээнд хэзээ ч хүрч байсангүй. Саяхны статистик судалгаагаар ядуурал 26,5 хувьтай байгаа юм уу даа. 3,5 сая хүн амтай, асар их боломж агуулсан жижиг улсын хувьд өндөр талдаа үзүүлэлт. 700-гаад мянган хүн хоёр идэхгүй, хоосон хонохгүй амьдардаг гэсэн дүр зураг харагдана. Хоёр сая хүн буюу нийт хүн амынх нь гуравны хоёр нь нийгмийн хalamжийн ямар нэгэн хэлбэрт хамрагддаг нь лавтай үнэн бол ядуурал сууриараа ерөөсөө хөдлөхгүй байна гэсэн дүгнэлт гарна. Ядуурлын суурь шалтгаан ядуурлын эсрэг цогц төлөвлөгөөнд ямар ч доргилт чичиргээ өгөхгүй амь бөхтэй оршиж бугшиж байна гэдгийг үүнээс илүү тоо баримтаар илэрхийлэх арга байхгүй. Энэ жил зуд турхантай хэцүүхэн онд орлоо. Хотоо харлуулсан малчдын "Хaan" банкинд тавьсан өр зээлийн 70 хувийг хөнгөлөх, нийгмийн даатгалын шимтгэлийн мөн л 70 хувийг төр хариуцах шийдвэр гарав. Төрийн мөнгө тэнгэрээс унадаггүй. Татвар төлөгчдийн хуруу хумсаа хуйхалж төлсөн

мөнгө нэгнийх нь халааснаас нөгөөгийнх нь халаас руу орж байгаа хэрэг. Энэ мөнгө нэгийг нь ядуурлаас суга татаж гаргана гэдэг магадлалын онолоор маруухан ч нөгөөг нь бол бараггүй нэрмэж хаядаг. Авсан, өгсөндөө өлзийгөө өгдөггүй. Ийм чөтгөрийн тойргийн уг үндсийг тасар татан хаях нь л ядуурлын эсрэг тэмцлийн үндсэн зорилго юм гэж УИХ-ЫН ГИШҮҮН Д. Батлут үзэж байна. Ядуурлыг янз бүрийн хalamж, хөнгөлөлтөөр шийдэхгүй. Ядуурал бол яг л Кихот ноёны тайрчихсан бошиг шиг бөгсөн биегүй морь хичнээн их ус залгилаад ч хөндий цээжээр нь олгойдож гараад цангаа нь тайлгадаггүй ёроолгүй сав юм. Мөнгөний сэтгэхүй гэж бий. Хүнд өгөх мөнгө дандаа их, хүнээс авах мөнгө дандаа бага санагддаг. Хalamжийн сэтгэхүй ч ялгаагүй. Төрөөс авч байгаа мөнгө үргэлж бага санагдана. Нэг хүнд өгөх дүнгээрээ бага ч нийт өгч байгаа нийлбэрээрээ хalamжид зарцуулж буй төрийн мөнгө ус цас шиг үрэлгэн байдаг. Тэгтэл Кихот ноёны бөгсгүй морь энэ ус цас шиг их мөнгийг уусан атлаа

уусан цалгилсан шинж огт байдаггүй. Арлагүй шүү дээ, хөндий цээжээр нь хэрэглээ болоод тэр чигээрээ гарчихаж байгаа юм чинь. Тэгэхээр бөгсгүй моринд бөгс залгах уу? Ёроолгүй саванд ёроол гагнах уу? Бүх юманд оролт, гаралтын систем байдаг. Орсон бол гарна. Гарсан бол орно. Бөгс залгасан ч гарна, ёроолтой байсан ч ууршина. Гол нь оролт, гаралтын систем жам ёсных байх ёстой, ухаалаг байх ёстой. Тэгж бөгс мөгс залгаж үргүй зардал гаргаж байснаас унаагаа юулсэн нь өлзийтэй. Өөрөөр хэлбэл мориныхоо хондлойг бус өөрийнхөө толгойг солих нь хавьгүй ашигтай. Үүнийг товчхондоо хүний хөгжил гэж хураангуйлж болно. Хүнээ л хөгжүүлэхгүй бол ядуурал сууриараа огт хөдөлдөггүйг тэрээр Орхон аймгийн Баян-Өндөр сумын орлогч дарга, Орхон аймгийн Засаг дарга байхдаа яс, махандaa тултал ойлгожээ. Хүүгүй бичил зээл олгох онц, жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл өгөх онц, гэр оронгүй иргэдэд А. Амарын талбай дээр айлсуулж барьж байгаад аятайхан, товхийсэн таван ханат өгөх онц, цаасан

# ЛИЙН ТУХАЙ БОДОЛ

дээр баримт болж дурайх сайн ажил. Гэхдээ л толгойд нь чиний амьдралыг чи л авч явна гэдэг ойлголт төрүүлэхгүй бол гэрээ газар нь дээр нь зараад архи болгодог "ядуу" хүн байдгийг тэр нүдээрээ харжээ. Тэгсэн дор "архи"-тай хүзүү сээрээ холбоод амраг хань шиг болчихсон мань эрийг "Элэг бүтэн Эрдэнэт" хөтөлбөрт хамруулчихвал адаглаад эртхэн эмчлүүлнэ. Өвчтэй хүнд юу ч байгаад нэмэргүй. Эрүүл хүн л баян. Одоо мань эрийн амьдрал суурьтай болоод эхэлж байгаа нь тэр. Энэ суурин дээр баттай гишгэсэн хүн юуг ч бүтээнэ. Амьдралаа бүтээнэ. Хөдөлмөрөөрөө бүтээнэ. Одоо дээр нь эрдэм боловсрол, ур чадвар, арга чаргаар дэмжээд өгөх хэрэгтэй. Тиймийн тулд хүний хөгжлийн суурийг тавьдаг багш, эмч нараа дэмжсэн "Багш", "Эмч" зэрэг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Орхон аймаг дахь БОЭТ бол Булган, Хөвсгөл, Орхон аймгийн 300 гаруй мянган иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг өндөр ач холбогдолтой байгууллага. УИХ-ын гишүүн Д.Батлутын ахалсан ажлын хэсгийн үр дүнд өнөөдөр тус байгууллагын 30 ажилтан орон сууц худалдан авах дэмжлэгтэй, нийт ажилчид цалингаа 20 хувь нэмэгдүүлж чаджээ. Цаашлаад анхан шатны эмнэлгүүд ч санхүүжилтээ хоёр дахин нэмж төсөв нь 307,6 тэрбумд хүрсэн байна. Тэрээр улсын төсөвт гурван тэрбум төгрөг суулгуулж БОЭТ Компьютер томографи болон ангиографийн аппарattай болжээ. Энэ бүхэн бодит ажил, бодит үр дүн. Тэрээр

ахмадуудаа ч марталгүй "Ач санах" хөтөлбөрөөр мялайлган цайлгасаар л явна.

Хүнийг хүнээр нь дамжуулж хөгжүүлнэ. Энэ бол хүний хөгжлийн арга зам. Ийм арга замд гар татах хэрэггүй. Үр дүн нь өнөө биш гэхэд маргааш найдвартай гарна. Өнөөх бичил зээлийг нь төр эрсдэлээ даагаад төрсөн санаа, төсөв төлөвлөгөөтэй нь наагаад өгөх хэрэгтэй. "Ийм бичил зээлийн эргэн төлөлт жижиг, дунд үйлдвэрийн 200-300 сая төгрөгийн эргэлттэй зээлийн эргэн төлөлтөөс хавьгүй өндөр

байна" гэж УИХ-ын гишүүн Д. Батлут Орхон аймгийн иргэд сонгогчидтой уулзалт хийж, тайлангаа тавих үеэрээ сэтгэл хангалаун өгүүлж байхыг сонссон.

Бид нар нэг л их бодлого шаарддаг. Д. Батлут гишүүн Орхон аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа бизнесийн төсөл, хөтөлбөрийг Шинжлэх ухаан технологийн парк байгуулж инкубатор маягаар бойжуулаад Үйлдвэрлэл технологийн паркт хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж үүнийгээ Бодлого гэж үзжээ.



Энэ бол иргэддээ бизнес эрхлэхэд тусалж буй нэгэн төрлийн бизнес Загвар юм. Энэ загварыг бизнес эрхлэх, хүн хөгжих таатай орчноор хангаж өгөх нь Төрийн бодлого гэж Д.Батлут гишүүн үздэг.

Тэрээр Улаанбаатар-Эрдэнэтийг холбосон хамгийн дөт зам буюу Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажилд 8 тэрбум, Эрдэнэт хотын доторхи авто замын засварт 50 тэрбум, Эрдэнэт хотын б-р бичил хорооллын уулзвараас Их Залуу багийн уулзвар хүртэлхи A1002 дугаартай улсын чанартай авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөхөд 13 тэрбум төгрөг, мөн VII хороолол, 2A хороололд 960 хүүхдийн сургууль барихад тус тус 4,7 тэрбум буюу нийт 9,4 тэрбум төгрөг улсын төсөвт батлуулсан нь түүний ажлын томоохон үр дүн, мөнөөх л бизнес эрхлэх, хүний хөгжлийн таатай орчин бүрдүүлэхэд оруулж буй дорвитой хувь нэмэр болно.

Бүх үр дүн бодлогын үр дагавар л байдаг. Зөвхөн 2023 онд өмнөх онтой харьцуулахад Орхон аймагт шинээр бий болсон ажлын байр 13,5 хувиар нэмэгджээ. Товчондоо бодлого боловсорч байна, хэрэгжиж байна. Товчондоо өөрийнхөө амьдралыг өөрөө авч яваа, бүтээж яваа нь л хүний хөгжлийн үр дүн юм.

Ер нь ядуурал гэж юу юм бэ? Дэлхийн стандартаар бол биологийнхoo энгийн хэрэгцээг хангах наад захын илчлэг, шим тэжээл авч чадалгүй өлөн зэлмэн амьдардаг хүмүүсийг хэлдэг. Шалтгаан нь олон янз ч гол

нь хүний сэтгэхүйд байна гэж УИХ-ЫН Д. Батлут үзэж байна. Төрийн хүнээ хөгжүүлэх, халамжлах бүх бодлого, үйл ажиллагаа "Хүн бол өөрийгөө тэжээх чадвартай амьтан" гэдэг тэр л хүчин зүйлийг наад захын гарааны цэгээ болгох ёстой гэж тэр үздэг. Байгаль, бурхан, нийгмээс заяатай энэ чадварыг л хөгжүүлэх ёстой. Ийм хүмүүс төлөвшүүлэх нь л төрийн бодлого. Иргэн баян бол улс баян. Иргэн хөгжилтэй бол улс хөгжилтэй. Зөвхөн хөгжсөн хүчирхэг иргэн л байгалийнхаа баялгийнхаа үр шимиийг хүртэж ч чадна, өртөг шингээж ч арвижуулж ч чадна. Өдгөө УИХ-ЫН гишүүн Д. Батлутын санаачилсан, эхлүүлсэн, түргэн хатдаг, Улаанбаатарт хүртэл борлогддог будгийн үйлдвэр зэргээр бодит үр дүн нь харагдсан "Үйлдвэрлэл технологийн парк"-ийн эрчим хүч, усан хангамж, төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил төслийн 1200 га талбайд ид өрнөж байна. Уг паркад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах зэсийн үйлдвэр, молибден боловсруулах үйлдвэр баригдана. Энэ бол зөвхөн Эрдэнэтийн ирээдүй, Эрдэнэтчүүдийн амьдралыг авч явах бүтээн байгуулалт биш. Бүс нутаг, цаашлаад улс орны эдийн засагт ч том өгөөжтэй Том төсөл. Манайхан Мега төсөл гэж ярьдаг даа. Хүн бүхэн сэтгэлийнхээ гүнд Мега сэтгэдэг Мега амьтан байдаг. Үүнийг л сэрээх, өдөөх, хөгжүүлэх, цочоох, хөрвүүлэх хэрэгтэй. Үүнийг л хүний хөгжил гэж УИХ-ЫН гишүүн

Д.Батлут гишүүн үздэг. Үүнийг л ядуурлыг язгуур үндсээр нь суга татан хаях Бодлого гэж тэр үздэг.

Швейцар улсын бүх хөрөнгө нь иргэд болон компанийн өмч байдаг. Иргэдийнх нь дундаж хөрөнгө санхүү 581 000 ам. доллар. Иргэн баян бол улс баян гэдэг зарчим энэ. Түүх эргэдэг. "Швейцарь лугаа хөгжье" гээд буруудсан Солийн Данзан, "Бүгдээрээ баяжья" гэдэг нь "Бүгдээрээ хөгжье" гэсэн үг шүү. Ингэж хөгжсөн цагт ядуурал сууриараа хөдөлнө.

Ер нь нарийндаа 0,7 газартай, сайн муу ч гэсэн өдөржин нар үздэг байшинтай хүн ядуу байхдаа ч яадаг юм бэ. Солонгост хэдэн байцаа тарих алгын чинээ газар, нар үздэг навтгар байшинтай болохын тулд даргынхаа өмнө насан туршдаа өөдөөс нь ч эгцэлж харж чадахгүй 90 градус бөхөлзөж явна шүү. Ядуурал хaa хамаагүй Дон Кихотын бөгсгүй адсагад бус бидний толгойд байгаа юм. "Бүгдээрээ баяжья" гэдэг лоозон дэвшиүүлсэн Гэндэн цагтаа сахал Сталины гаансыг хуга алгадаж байсан цэс ихтэй эр байв. Монголчууд бид нар цэстэй, цэстэй. Юу л байна цэс байна. Одоо харин хүн алгадаж болохгүй, хуультай. Харин толгойг бол сайн түнших хэрэгтэй шүү. ■

Б. Баттогтох.

**Орон нутгийн  
орчинтой илүү  
танил орон нутгийн  
пүүсүүдтэй  
өрсөлдөхийн тулд  
гадаадын шууд  
хөрөнгө оруулагч  
нь өөрийн үйл  
ажиллагааг олон  
зах зээлд ашиглаж  
боловхуйц, үүний  
зэрэгцээ нэмэгдэл  
зардал шаардахгүй  
ур чадвар, хөрөнгөд  
суурилуулдаг.  
Үндэстэн дамжсан  
компаниуд нь  
өөрсдийн технологийн  
давуу талыг тэдний  
хамгийн хүчтэй давуу  
тал гэж үздэг. Харин  
үүний дараагаар  
зах зээлийн болон  
удирдлагын ур чадвар  
ордог.**

**Н**эгэнтээ УИХ-ын гишүүн Д.Батлутаас орон нутагт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах боломж хэр байдгийг сонирхсон юм. Мань эр орон нутгийн удирдлагаас УИХ-д суусан цөөн түшээдийн нэг л дээ. Тиймдээ ч онцолж асуусан хэрэг. Тэр “Яг үнэндээ дэлхийгээр дүүрэн мөнгө байна. Би Орхон аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа Герман-Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны хуралд оролцсон юм. Хурлын үеэр Герман талаас, Монголд хэрэгжүүлнэ гэвэл 49 тэрбум еврогоор санхүүгүүлэх боломжтой. Монгол Улсаас санал болгох төсөл байна уу гээд хариу өгөөгүй тул байхгүй гээд алх цохихыг харсан. Хайран мөнгө, хайран шүү.

Би Германд очоод ганц цагийн хуралд суухдаа л тийм боломж байдгийг олж харсан. Үнэхээр дэлхийгээр дүүрэн боломж бий. Заавал төр засаг гээд суугаад байх шаардлагагүй. Тэр боломжуудыг бид хамгийн зөв загвараар нь татах боломж

хаа сайгүй бий. Гагцхүү төр боломжийг нь олгоод, тэр хувийн хэвшилтэйгээ хамтраад ажиллах юм бол үйлдвэрлэл хөгжүүлэх, банк санхүүгийн чөлөөт орон зайд маш том боломж бий. Энгийнчилбэл, зээлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бололцоо бүр маш их бий.” хэмээн хариулсан.

Эргээд харах нь ээ, Эрдэнэт гэх zaluuhan хотын иргэншил, иргэдийн төлөвшил нь их өөр юм билээ, бусад бүс нутгийнхантай харьцуулахад... Илгээлтийн эздийн итгэл зүтгэлээр өндийсөн эл суурин ирээдүйд эх орныхоо инновацийн өлгий бааз болно гэсэн zaluuusyn мөрөөдлөөр тэжээгдэн, алс ирээдүйгээ тодорхойлсон содон бодлоготой. Бусад аймаг сумдтай харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалтаар гайхамшигийг бүтээж, нутагшуулж болно гэдгийг харуулсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага төсөл ч элбэгтэй аж.

Дэлхийгээр дүүрэн мөнгийг

# ДЭНЖДЭЭ ТАТАХ БОЛОМЖ

## ЭРДЭНЭТИЙН ЗАЛУУС ДЭЛХИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭРГЭДЭЭСЭЭ ЭЗЭМШИНЭ

Зах зухаас нь сонирхуулахад, Орхон аймагт өнгөрсөн дөрөвдүгээр сард АНУ-ын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны дарга John Brown-ыг Төрийн ордонд хүлээн авч уулзах үеэр хөндөгдсөн American Corner буюу Америкийн Соёл Мэдээллийн төвийг

Эрдэнэт хотод байгуулах ажил амжилттай үргэлжилж байна. Эрдэнэт хотод шинээр баригдаж буй Номын өргөөнд үйл ажиллагаа явуулах тус төв ашиглалтад орсноор англи хэлээр олон төрлийн хөтөлбөр, лекц яриа, сургалт явуулах бөгөөд англи хэл дээрх ном

бүхий уншлагын танхим, лавлагaa материал, чөлөөтэй ашиглах компютерүүдээр үйлчилнэ. Түүнчлэн аудио, видео техникиүүдээр бүрэн тоноглогдож, АНУ-д боловсрол эзэмших хүсэлтэй залууст зориулан АНУ-ын их дээд сургуулиудын албан ёсны мэдээллээр хангах юм.



## ХОГИЙГ БАЯЛАГ БОЛГОХ ҮЙЛДВЭР АШИГЛАЛТАД ОРСНООР ХӨРСӨН ДЭЭРХ ХОГ ХАЯГДАЛ 50 ХУВИАР БУУРНА

“Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийг Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхээр Польш улсын ППЭЧ Мелиорекс ХХК шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гэрээг Орхон

аймагтай 2019 оны долдугаар сарын 23-ны өдөр байгуулж, гэрээний нийт үнийн дун 9 сая евrog шилжүүлжээ.

Төлбөр хийгдсэнээс хойш 2020 оны есдүгээр сарын 17, 18-нд Польш улсаас 5 тир машин, нийт 108 тонн барилгын караказ төмөр Эрдэнэт хотын гүний гааль дээр буусан ч Ковид-19 цар тахлын улмаас хойд хил хаагдаж, тээвэрлэлт түр зогсжээ. Өөрөөр хэлбэл, 2021 онд нэмж ачаа ирээгүй бөгөөд 2022 оны 8, 9, 11 дүгээр сард нийт 5 тир машин үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материал ирсэн хэмээн албаны хүн тайлбарласан. Тодруулбал, төслийн хүрээнд гэрээнд заасны дагуу зургаан төрлийн 12 машин механизм нийлүүлэх ба тээвэрлэлтийн хуваарийн дагуу 2022 оны 8, 11 дүгээр сард 12 машин хэсэгчлэн орж иржээ. Эдгээр машиныг 2023 оны хоёр дугаар сард аймгийн Хот тохижуулах

газарт хүлээлгэн өгсөн бөгөөд өнөөдрийн байдлаар хорооллуудын хог ачилтад бүрэн ажиллаж байгаа аж. Өнөөдрийн байдлаар гэрээний хүрээнд хог хаягдлыг татан зайлуулах машин механизмыг шинэчлэх ажил бүрэн хийгдэж, үйлдвэрийг усаар хангах гүний худгийг гаргаж, үйлдвэрийн дэргэд цахилгааны дэд станцыг байгуулан, хог ангилах үйлдвэрийн барилгын ажил, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралтын ажил ид өرنэж байна.

Дэлхий даяар дэгдсэн цар тахлын улмаас хойшилсон ч Эрдэнэт хотын хатуу хог хаягдал боловсруулах үйлдвэр 2024 оны долдугаар сард ашиглалтад ороход бэлэн хэмээн Мелиорекс компанийнхан тодотгосон. Үйлдвэр ашиглалтад орсноор Орхон аймгийн 83.3 га талбайг хамардаг хог хаягдлын төвлөрсөн хоёр цэгт хуримтлагдаад буй 6 сая шоо метр хог хаягдал 30-50 хувь буурах юм.

Товчондоо дэлхийгээр дүүрэн мөнгөнд бас онцлог бий. Өөрөөр хэлбэл монголчууд маш том нөөцтэй болчихсон. 280 мянган монгол хүн дэлхий дайдаар тэнүүчилж бүх юмыг үзэж, нүд тайлчихаад маниусыг их тэнэгтэж байна даа гэж харж, мэддэг болчихсон. Гаднын иргэншилтэй ч эх орноо гэсэн халуун сэтгэлтэй монголчуудын арми хилийн чинадад бий Дэлхийгээр тарсан 280 мянган иргэндээ илүү боломж олгож, орон нутагт хөрөнгө оруулалт татах бас нэг боломж гэх гээд байна л даа.



АНУ-ЫН Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны дарга Жон Брауны хамт

“ Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүн энэ ажлыг хийснээр, ийм шийдвэр гаргаснаар үр дүн нь бусдад яаж нөлөөлөх бол гэж хамгийн түрүүнд бодож үздэг байх хэрэгтэй. Аль болох олон хүний амьдралыг зөргээр өөрчлөх гэж л шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа биз дээ.

# ЭРГЭХ ХОЛБОО

УИХ-ын гишүүн Д.Батлут Орхон аймаг, Эрдэнэт хотын иргэд, сонгогчидтой олон уулзалтыг зохион байгуулжээ. Тэрээр 2020 онд 23 багийн 2060 иргэнтэй, 2022 онд 2124 иргэнтэй, 2023 онд 1746 гэх мэтээр нийт 5930 иргэнтэй уулзсан байна.

Мөн Орхон аймгийн төрийн байгууллагуудад зочилж хамт олонтой нь олонтаа уулзсан байдал. Тухайлбал, 2022 онд 8 байгууллагын 666 ажилтантай, 2023 онд 27 байгууллагын 2604 ажилтантай, 2023 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 375 ажилтантай нийт 40 гаруй төрийн байгууллагын 3645 ажилтантай уулзжээ.

## Орхон аймаг Эрдэнэт хотын иргэд, сонгогдоос **2020-2023**

2020 онд

**125**

2021 онд

**656**

2022 онд

**554**

2023 онд

**883**



## Өрхийн бичил, бизнес эрхлэгчдийг дэмжиж олгосон хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж **2020-2023**

### Тоног төхөөрөмж

**194** Зөөлөн оёдлын тоног төхөөрөмж

**26** Хатуу оёдлын тоног төхөөрөмж

**22** Мужааны багаж хэрэгсэл

**11** Дарханы багаж хэрэгслүүд

**1** ХАА-Н ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

**34** Хүнсний тоног төхөөрөмж

**347** Бусад тоног төхөөрөмж

### Хүлэмж

**58** 4x8 харьцаатай хүлэмж

**20** 6x10 харьцаатай хүлэмж

**59** 6x20 харьцаатай хүлэмж

347 иргэнд нэг тэрбум гаруй төгрөгийн тоног, төхөөрөмж олгожээ. Үүнийг Өрхийн бичил, бизнес эрхлэгчдийг дэмжихэд зориулж улсын төсөвт хөрөнгийг нь тусган 2023 онд олгосон байна.

2024 оны төсөвт

**2.5** тэрбум төгрөг

нэмж тусгуулаад байгаа юм.

## СОНГОГЧДООС ИРСЭН 2021 САНАЛ ХҮСЭЛТИЙН

# 85.2%-ИЙГ ШИЙДВЭРЛЭЖЭЭ

**УИХ-ЫН ГИШҮҮН**  
**Д.Батлут 2020-**  
**2023 ОНЫ ХООРОНД**  
**АЖИЛЛАХ ХУГАЦААНД**  
**СОНГОГЧДЫН ЗҮГЭЭС**  
**2021 САНАЛ ХҮСЭЛТ**  
**ИРСНИЙ 85.2 ХУВИЙГ**  
**ШИЙДВЭРЛЭН**  
**АЖИЛЛАЖЭЭ.**

**2023** Иргэдээс нийт 686 санал хүсэлт ирснийг задалваас ажил хүссэн 56 санал ирсний 27-г буюу 48. хувь, орон сууцтай холбоотой 24 хүсэлтийн 3 буюу 12.5 хувь, гэр болон бусад хүсэлт 10 ирсний 7-г буюу 50 хувь, газар шугам сүлжээний

өргөтгөл шинэчлэл хийх 10 хүсэлтийн 9 буюу 90 хувийг шийдвэрлэжээ. Мөн өрхийн үйлдвэрлэл ажлын байр хүссэн 296 хүсэлтийг 100 хувь, хууль тогтоомж болон ТЗБ-д санал хүргүүлэх 17 хүсэлтийн 5 буюу 29.4 хувийг шийдвэрлэжээ.

**2022** Нийт 554 санал хүсэлт ирснээс ажилд орох 38-12 буюу 31.5 хувь, орон сууц хүссэн 31-30 буюу 92.2 хувь, гэр болон бусад 22 хүсэлтийн 9 буюу 36.3 хувь, газар шугам сүлжээний 9 хүсэлтийн 6 буюу 33.3 хувийг шийдвэрлэжээ. Мөн өрхийн үйлдвэрлэл ажлын байр бий болгох хүсэлт 104 ирсний 67-г буюу 31.4 хувь, хууль тогтоомжид болон ТЗБ-д санал хүргүүлэх 4 хүсэлтийг

100 хувь уламжилж хариу өгөн ажилласан аж.

**2021** 2021 онд сонгогчдын зүгээс нийт 656 санал ирсний 56 нь ажилд зуучлах хүсэлт байсны 47-г шийдвэрлэсэн нь 48.2 хувь, орон сууц хүссэн 24 хүсэлтийн 3-г буюу 12.5 хувь, гэр болон бусад хүсэлт 10 ирсний 5-г буюу 50 хувь шийдвэрлэжээ. Тухайн онд өрхийн үйлдвэрлэл ажлын байр бий болгох хүсэлт 22 ирсний 11-г 61.1 хувь, хууль тогтоомж болон ТЗБ-д санал хүргүүлэх 17 хүсэлтийн 5 хувь буюу 29.4 хувийг шийдвэрлэн эргэх холбоотой ажиллажээ.

**2020** Сонгогчдоос илгээсэн нийт 656 ирснээс ажилд орох 23 саналын 11-г шийдвэрлэсэн нь 47.8 хувь, орон сууц хүссэн 26 хүсэлтийн 17-г буюу 60.7 хувь, гэр болон бусад хүсэлт 5 ирсний 3-г буюу 80 хувь, өрхийн үйлдвэрлэл ажлын байр бий болгох хүсэлт 11 ирсний 4 буюу 40.6 хувийг шийдвэрлэхэд УИХ-ын гишүүний зүгээс санаа тавин ажилласан байх юм.





# ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ИТГЭЛЦЛИЙН ХҮЧ



Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж тэдэнд итгэл өгснөөр ажилгүйдэл буурч өрхийн эдийн засаг тогтвортожиж буйг харахад урамтай. Өнгөрсөн жилүүдийн өрхийн үйлдвэрлэлд дэмжлэг авсан иргэн энэ жил нэгээс хоёр ажлын байр бий болгож буй нь ололт амжилтын эхлэл болох нь гарцаагүй. Өнгөрсөн жилүүдэд өрхийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжиж 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт буюу шаардлагатай тоног төхөөрөмжийг 500 гаруй өрхөд олгожээ.



ХӨВСГӨЛ·БУЛГАН·ОРХОН

# Хамтгаа

